Хавсралт 1

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
## (2018 оны жилийн эцсийн байдлаар)

*Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар*

2019-01-11 Улаанбаатар хот

| Шийд-вэрийн д/д | Заал-тын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалт, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч буй шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| **Нэг. УИХ-ын тогтоол** | | | | | |
| 1 | 1 | **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай**<br>2016-11-03, № 51<br>2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд зориулж 157,832.8 мянган төгрөгийг байгууллагын төсөвт тусган батлуулж, мэдээллийн ил тод байдлыг хангах, цахим худалдан авах ажиллагааг зохион байгуулах, албан хаагчдыг соён гэгээрүүлэх, худалдан авах ажиллагааны чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн ажилд нийт 157,519.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| 2 | 2 | **Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай**<br>2016-11-10, № 64<br>3.1. Төрийн өмчийг 2017-2018 онд хувьчлах үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар батлах хүртэл төрийн өмчийг | **ТӨБЗГ – БТУХ**<br>Энэхүү тогтоолоор батлагдсан жагсаалтад заасан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн байгуулах ажлыг хэрэгжүүлэх хүрээнд,<br>– 2015-2016 онд “Монгол шуудан” ТӨХК, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-иас нэмэлт хувьцаа гарган худалдаж, 7.4 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн бөгөөд эдгээр компани нь төрийн өмчийн оролцоотой компани болж, нийт хувьцааны тодорхой хувь нь хувьд шилжсэн;<br>– 2016-2017 онд “Кино урлагийн дээд сургууль” ХХК, “Хөтөлийн | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | ТӨБЗГ-аас хийвэл зохих шаардла-гатай ажлуудыг хийсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хувьчлах ажлыг Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн дагуу үргэлжлүүлэн зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т зөвшөөрсүгэй. | цемент шохой" ТӨХК, "Оргил рашаан сувилал" ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг бүрэн худалдаж, нийт 16.9 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээр төрийн өмчийн оролцоогүй болж, хувьд бүрэн шилжсэн;<br>– 2018 онд "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн нэмэлт хувьцаа гаргах бэлтгэл ажлыг хийсэн.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2017 онд хувьчлах хуулийн этгээдийн жагсаалтыг боловсруулан Засгийн газарт хүргүүлсэн, шийдвэрлэгдээгүй.<br><br>Улсын Их Хурлын "Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай" тогтоолын төслийг холбогдох яам болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын саналыг авсны үндсэн дээр боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Уг төсөлд нийт 18 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 19 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 37 хуулийн этгээдийг хувьчлах талаар тусгагдсан. Дээрх тогтоолын төсөл бүхий саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр Улсын Их Хуралд өргөн барьсан. Улсын Их Хурал тус саналыг хэлэлцээд, Эдийн засгийн байнгын хорооны дэргэд Ажлын хэсэг байгуулан зарим судалгаа тооцоог хийх чиглэл өгсөн. | | |
| 3 | 3 | **"Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2017-02-23, № 23<br><br>2. Оросын Холбооны Улсын Засгийн газрын эзэмшлээс "Монголиан Коппер Корпорейшн" ХХК-д шилжсэн "Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн өмчид шилжүүлэн авах асуудлыг яаралтай шийдвэрлэж, төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Ш.Раднаасэд/, Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>УИХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 06 дугаар тогтоолоор "Монголросцветмет" ХХК-ийн, 07 дугаар тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн дүрмийг 100 хувь төрийн өмчит ХХК байхаар тусган баталж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн 10, 11 дүгээр тогтоолоор тус компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилж, 100 хувь төрийн өмчит ХХК-ийн статустай үйл ажиллагаа явуулах арга хэмжээ авсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | ТӨБЗГ-аас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тул цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | даалгасугай. | | | |
| | 4 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2017-02-23, № 23<br><br>3. “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг Хөгжлийн банк болон Монголбанкнаас Худалдаа хөгжлийн банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө, ногдол ашиг, вексель зэрэг эх үүсвэрээс суутган тооцох хэлцэл хийж төрийн өмчид авах арга хэмжээг зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Ш.Раднаасэд/, Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 151 дүгээр захирамжийн 2 дугаар заалтаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааны төлбөрийг Хөгжлийн банк болон Монголбанкнаас Худалдаа хөгжлийн банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө, ногдол ашиг, вексель зэрэг эх үүсвэрээс суутган тооцох замаар хийх, хувьцааг төрийн өмчид авах арга хэмжээг зохион байгуулах дэд ажлын хэсэг байгуулан ажиллахыг Сангийн сайдад зөвшөөрсөн. Засгийн газраас 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн “Хувьцааг төрийн өмчид бүртгэх, холбогдох төлбөрийг суутган тооцох тухай” 07 дугаар тогтоолын 1 дэх заалтаар “Оросын Холбооны Улсын Засгийн газрын эзэмшлээс “Монголиан Коппер Корпорейшн” ХХК-д шилжсэн “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцаанд төлсөн 400.27 (дөрвөн зуун сая хоёр зуун далан мянган) сая ам.доллар төлбөрийг суутган тооцох эх үүсвэрийн жагсаалтыг баталж, хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хариуцуулсан. Хувьцааны төлбөрийг суутган тооцох ажлыг хариуцах эздээр Сангийн сайд, Үндэсний хөгжлийн газрын дарга, Монгол банкны ерөнхийлөгч, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Хөгжлийн банкны ТУЗ-ийн даргыг тус тус томилсон.<br><br>Иймд “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааны төлбөрийг суутган тооцох асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хариуцахгүй болно. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-ХБ | Хэрэгжилт нь ТӨБЗГ-аас хамаарах-гүй байна. Иймээс цаашид хяналтаас хасах саналтай. |
| | | **УИХ-ын тогтоол: 3 шийдвэрийн 4 заалт** | **100% - 3 заалт; ХБ – 1 заалт; Хэрэгжилтийн хувь - 100.0%.** | | |
| **Хоёр. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |
| 4 | 5 | **Монгол Улсын Төрийн тугийг хүндэтгэх тухай**<br><br>2017-06-16, № 136<br><br>1.Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг гүнээ дээдлэн хүндэтгэж байхыг иргэдэд уриалсугай. 2.Есөн хөлт Их цагаан тугийг дууриалган үйлдсэнийг төр, олон нийтийн аливаа үйл ажиллагаанд | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан тугийг дээдлэн хүндэтгэж байх, Есөн хөлт Их цагаан тугийг дууриалган үйлдэхгүй байх, дууриалгаж хийсэн Их цагаан тугийг төр, олон нийтийн аливаа үйл ажиллагаанд ашиглахгүй байхыг нийт албан хаагчдад танилцуулав. ТӨБЗГ-ын албан хаагчдын дунд 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулсан “Хууль тогтоомж сурталчлах сарын аян”-ы хүрээнд зохион байгуулсан “АХА” тэмцээн, уг тэмцээний шилдэг оролцогчдын дунд зохион байгуулсан | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ашиглахгүй байхыг төрийн захиргаа, нутгийн өөрөө удирдах болон холбогдох бусад байгууллагад даалгасугай. | “Жаран мянгын уналт” хөгжөөнт уралдаант танин мэдэхүйн асуултад Их цагаан тугны тухай асуулт оруулж, албан хаагчдын мэдлэгийг бататгасан. | | |
| 5 | 6 | **Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил зарлах тухай**<br>2018-04-11, № 38<br>3. Авлигын хор уршиг, хохирлыг ухамсарлах, авлигаас татгалзах, авлигыг үл зөвшөөрөх үзлийг үйл ажиллагаандаа баримталж, түгээн дэлгэрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, компани, аж ахуйн нэгжүүдэд уриалсугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Уриалгыг нийт албан хаагчид болон харьяа төрийн өмчит хуулийн этгээдэд хүргэн сурталчлан мэдээлэв. Байгууллагын цахим хуудас, дотоод сүлжээгээр дамжуулан олон нийтэд болон албан хаагчдад мэдээлсэн. Авлигын хор уршиг, хохирлыг ухамсарлах, авлигаас татгалзах, авлигыг үл зөвшөөрөх үзлийг үйл ажиллагаандаа баримтлах, түгээх дэлгэрүүлэхэд 2018 онд АТГ-ын Олон нийтийн төвд зохион байгуулсан сургалт зохих нөлөөг үзүүлэх ажил болсон. 2018 онд тус төвд зохион байгуулсан авлигын эсрэг 30 удаагийн суурь сургалтад ТӨБЗГ болон харьяа төрийн өмчит 39 хуулийн этгээдийн нийт 488 албан хаагчийг хамруулсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | | **Ерөнхийлөгчийн зарлиг:<br>2 шийдвэрийн 2 заалт** | **100% - 2 заалт; Хэрэгжилтийн хувь - 100.0%.** | | |
| **Гурав. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж** | | | | | |
| 6 | 7 | **Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай**<br>2017-07-19, № 19/5<br>3. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхлэх асуудлын хүрээнд энэ чиглэлээр үүссэн гомдол, маргаан байхгүй байна. Цаашид Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийг анхаарч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | | **ҮАБЗ-ийн зөвлөмж: 1 шийдвэрийн 1 заалт** | **100% - 1 заалт; Хэрэгжилтийн хувь – 100%.** | | |
| **Дөрөв. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 7 | 8 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулах тухай**<br>2013-10-05, № 336<br>3. Монгол Улс ба Нордикийн хөгжлийн сан хооронд байгуулсан зээлийн | **ТӨБЗГ - БТУХ**<br>Санхүү, эдийн засгийн яам (хуучнаар) “Авто тээврийн газар”-ын хооронд 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан 122/11/55/ дугаар гэрээний хавсралт дахь дамжуулан зээлдүүлэхэд өөрчлөлт оруулан зээлийн төлбөрийн хуваарийг шинэчлэн, зээлийг төлж эхэлсэн. 2017 онд зээлийн үлдэгдлийг Сангийн яамны Өрийн | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэлэлцээрийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдлийн тооцоог гаргаж баталгаажуулах, Автотээврийн үндэсний төвтэй дамжуулан зээлдүүлэх гэрээг шинэчлэн байгуулж зээлийн эргэн төлөлтийг тус төвийн жил бүрийн зорилтот түвшинд тусган барагдуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Зам, тээврийн сайд А.Гансүх нарт даалгасугай. | удирдлагын хэлтэстэй тооцоо нийлэн баталгаажуулж, 2013 оноос хойш төлөгдөөгүй байсан үндсэн болон зээлийн хүүгийн зардалд нийт 1,914,263,148 төгрөгийг төлсөн. Зээлийн эргэн төлөлтийг үйлдвэрийн газрын жил бүрийн зорилтот түвшинд тусгах арга хэмжээ авахыг даалгасны дагуу 2018 оны зорилтот түвшинд тусган Нордикийн хөгжлийн сангийн зээлийн хүүгийн зардалд 62.0 сая төгрөг, зээлийн үндсэн төлбөрт 411.0 сая төгрөгийг тус тус Сангийн яамны дансанд төлж барагдуулсан. Зээлийн эргэн төлөлт одоогийн байдлаар 54.3 хувийн гүйцэтгэлтэй байна. | | |
| 8 | 9 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2016-12-21, № 193<br><br>1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах бэлтгэл хангах ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан ТӨБЗГ-ын даргын 2018 оны А/08 дугаар тушаалаар байгуулан ажиллуулав. “Хөрөнгийн үнэлгээний талаар авах зарим арга хэмжээ, бэлтгэл ажлыг хангах тухай зөвлөмж”-ийг боловсруулан төрийн болон орон нутгийн өмчит 6000 гаруй хуулийн этгээдэд хүргүүлэн хэрэгжилтийг хангуулав. Үнэлгээний ажлын чиглэлээр ГЗБГЗЗГ-тай “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулж, нийслэлийн Газрын алба, 21 аймгийн ОНӨГ, ГХБХБГ-тай хамтран ажиллав.<br><br>ТӨБЗГ-ын 2018 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн талаар авах арга хэмжээний тухай” 273 дугаар тогтоолоор үнэлгээнд хамрагдах үл хөдлөх хөрөнгийг хөрөнгийн үнэлгээний болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу дансны нэг ангид бүртгэх арга хэмжээ авч, нийт төрийн өмчит хуулийн этгээдийг хамруулан хэрэгжилтийг хангуулав.<br><br>Үнэлгээний аргачлал, заавар, журмыг боловсруулах мэргэжлийн үнэлгээчдийн багийг ажиллуулж, үнэлгээний аргачлал, зааврын төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсний дүнд Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалаар “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал” батлагдсан бөгөөд ТӨБЗГ-аас үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав.<br><br>ТӨБЗГ-ын ажилтнууд үнэлгээний аргачлал, зааврыг танилцуулах, арга зүйн семинар, зөвлөгөө, зааварчилга өгөх, орон нутаг дахь үнэлгээний ажилд явцын хяналт хийж, үр дүнг 2018 оны санхүүгийн тайланд тусгуулах асуудалд нягтлан шалгалт хийх чиглэлээр 21 аймаг тус бүрт 2 удаа ажиллав. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 10 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-12-21, № 193<br>2. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын эзэмшилд байгаа Монгол Улсын төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг тухайн орны үнэлгээний жишигт нийцүүлэн үнэлүүлж санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулахыг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Гадаад улсад байгаа Монгол Улсын төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлын бэлтгэл хангах хүрээнд ТӨБЗГ-ын даргын 2018 оны А/65 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгүүд Монгол Улсаас гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж, зохих баримт бичигтэй танилцан, газар өмчлөх эрх болон үл хөдлөх хөрөнгийг тоолох, хэмжилт хийх, үнэлбэл зохих хөрөнгийн тоо хэмжээ, чанар байдлыг тодорхойлон нягтлан шалгаж, жагсаалт бэлтгэх, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг судалгааны маягтын дагуу бэлтгэх, акталж данснаас хасах хөрөнгийн саналыг хянаж, материалын бүрдлийг хангуулж авах зэрэг ажлыг газар дээр нь хийж гүйцэтгэв.<br>Үр дүнг 2018 оны санхүүгийн тайланд тусгуулахаар ажилласан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 11 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-12-21, № 193<br>3. Концессын гэрээний дагуу барьж байгуулсан барилга, зам, гүүрийн байгууламж, тоног төхөөрөмж болон бусад концессын зүйлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авч, төрийн өмчийн бүртгэлд тусгах асуудлыг тухай бүр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлж байхыг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Концессын гэрээгээр шинээр бий болсон эд хөрөнгийг Концессын тухай хуулийн 2.4 дэх зүйлд “...концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчид авах, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар тус тус зохицуулна” гэж заасан. Үүний дагуу концессын төрлөөр болон концессын гэрээнд ямар нөхцөл байгааг судалсны дараагаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.2, 5.1, 5.2, 5.3 дахь заалтыг үндэслэн НББОУС-ын дагуу данс бүртгэлд бүрэн тусгах, мөн шилжүүлэн авах байгууллагын саналыг авч, холбогдох баримт материалыг бүрдүүлж ирүүлэн, шийдвэрлүүлж байх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны А-5/37 дугаар албан бичгийг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-ХБ. | Үндэсний хөгжлийн газарт даалгасан, ТӨБЗГ-аас шууд хамаарах-гүй. |
| | 12 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-12-21, № 193<br>5. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх болон тухайн хөрөнгийг төрийн байгууллагад | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад энэ асуудлыг тусгасан. Уг хуулийг дагаж мөрдөх журамд холбогдох асуудлыг тусгах талаар арга хэмжээ авч байна.<br>Улсын бүртгэлийн ерөнхий газрын боловсруулсан "Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журам"-ын төслийг судлан үзээд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | ТӨБЗГ-аас холбогдох зохион байгуулалтын арга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг судлан, тодорхой санал боловсруулж, 2017 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | зарчмын саналыг уг журамд тусгаагүй буюу тодорхойгүй хэвээр үлдээсэн байна. Тухайлбал: орон нутгийн өмчийн 4500 гаруй хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх эсэх, төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг анхны удаа, хялбаршуулсан байдлаар бүртгэх асуудлыг зохицуулсан эрх бүхий байгууллагын шийдвэрийг гаргуулах, бүртгэхэд гарах улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлсний хувьд төсөвт байгууллага болон компани, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт ялгаатай байдлаар зохицуулалт хийх шаардлагатай. Энэ талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны А-1/4585 дугаар албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | | хэмжээг авч, хэрэгжүүлсэн.<br><br>ТӨБЗГ-аас шууд хамаарах-гүй. |
| 9 | 13 | **Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2017-01-04, № 6<br><br>4. Олон улсын гэрээ, конвенцид заасан болон олон улсын байгууллагаас тогтмол зохион байгуулдаг хурал, зөвлөгөөн, арга хэмжээнээс бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулах олон улсын хурал, зөвлөгөөнийг жил бүрийн 9 дүгээр сараас дараа оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд зохион байгуулж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулахаар төлөвлөгдөөгүй. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”–ХБ. | Хяналтаас хасах саналтай. |
| 10 | 14 | **УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай**<br><br>2017-02-01, № 42<br><br>1. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн зээлийн багцыг Хөгжлийн банкнаас Засгийн газарт шилжүүлэхтэй холбогдуулан төсөл санхүүжүүлэх зорилгоор Хөгжлийн банктай байгуулсан холбогдох зээлийн гэрээг дүгнэж эрх үүргийг шилжүүлэн | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>“Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК-ийн зээлийн хөрөнгөтэй холбоотой асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хөгжлийн банкнаас байгуулагдсан Ажлын хэсэг хариуцан ажилласан болно. “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай холбоо тогтоох боломжгүйгээс шалтгаалан зээлийн гэрээ дүгнэсэн актад “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК-ийг төлөөлөн гарын үсэг зурах бүхий этгээдийг томилох шаардлага үүссэн тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 438 дугаар тогтоолоор ажлын хэсгийн дүгнэлттэй танилцах, Хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээг дүгнэх, дүгнэсэн актад гарын үсэг | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | авах, дуусгавар болгох, баримт бичгийг хэлээлцэх үүрэг бүхий Ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | зурах эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд олгосон. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс зээлийн гэрээ, зээл төлөлтийн талаар мэдээлэлтэй урьдчилан танилцаад гэрээ дүгнэсэн акт бэлэн болмогц гарын үсэг зурах тухай мэдэгдсэн.<br>Хөгжлийн банкны зүгээс гэрээ дүгнэсэн актыг бэлтгэх, зээл төлөлтийн дүнг нарийвчлан тооцоолох, холбогдох байгууллагуудаас санал авах үйл ажиллагаа хийгдэж байгаа тул гэрээг дүгнэж, гарын үсэг зурах ажил хойшлогдоод байна. | | |
| | 15 | **УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай**<br>2017-02-01, № 42<br>2. Ажлын хэсгийн тайлан, үр дүнг 2017 оны 2 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг төслийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Хөгжлийн банкны зүгээс гэрээ дүгнэсэн актыг бэлтгэх, зээл төлөлтийн дүнг нарийвчлан тооцоолох, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэх ажил хийгдэж байгаа тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хамааралгүйгээр гэрээ дүгнэх ажил хойшлогдсон болно. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 11 | 16 | **Тогтоол хүчингүй болгох тухай**<br>2017-03-20, № 96<br>5. Энэ тогтоолын 3 дугаар зүйлд заасны дагуу хөндлөнгийн аудит хийлгэхэд шаардагдах зардлыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгах замаар шийдвэрлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ТӨБЗГ-ын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 306 дугаар тогтоолоор баталсан тул уг зардал тухайн үед тусгагдаагүй. ТӨБЗГ-ын 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2018 оны зорилтот түвшинд тодотгол оруулан асуудлыг шийдвэрлэсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 12 | 17 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2017-03-29, № 102<br>1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, “Роял Грийн Вилла” хотхоны 62/8 дугаар байрны | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>ТӨБЗГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууц, зогсоолыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай асуудлыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, 2017 оны 252 дугаар тогтоолоор худалдах доод үнэ, дэнчингийн хэмжээг тогтоож, нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулахаар шийдвэрлэв. Уг шийдвэрийн дагуу нээлттэй дуудлагын худалдаа явуулах тухай зар мэдээг Өнөөдөр сонин болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан зарлан мэдээлсэн. Нээлттэй дуудлага худалдааг 4 удаа зарлан зохион байгуулсан боловч оролцогч | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Нээлттэй дуудлага худалдааг 4 удаа зарласан боловч нэг ч оролцогч ирээгүй тул удааширч байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Б1/103 тоотод байрлах 160 м.кв талбай бүхий орон сууц, мөн байрны зоорийн давхрын 2 тоот автомашины зогсоол, Г62/10 дугаар байрны 59 тоот автомашины зогсоолыг тус тус нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | ирээгүй.<br>Худалдаж авах этгээд тодорхой болоогүй тул хөрөнгийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор албан ажлын конторын зориулалтаар ашиглах болсон. | | Цаашид хяналтаас хасах саналтай. |
| | 18 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2017-03-29, № 102<br>2. Дуудлагын худалдааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Дуудлагын худалдаагаар хөрөнгө худалдагдсан тохиолдолд орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ. Энэ талаар “Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай” ТӨБЗГ-ын хуралдааны 2017 оны 252 дугаар тогтоолд тусгагдсан. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Нээлттэй дуудлага худалдааг 4 удаа зарласан боловч нэг ч оролцогч ирээгүй тул удааширч байна.<br>Цаашид хяналтаас хасах саналтай. |
| 13 | 19 | **Хөндлөнгийн хяналт тавих тухай (Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”)**<br>2017-06-20, № 177<br>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог зохих журмын дагуу хянаж шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба)-д даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж, дүгнэлт гаргах үүрэг бүхий хуулийн этгээдээр шалгарсан Итали улсын “Кинетик Технложи” компанийн гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний зардал болох 335.6 мян.ам.долларын санхүүжилтийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хариуцуулахаар Засгийн газраас шийдвэрлэсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн, “Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах тухай” А-1/3056 дугаар албан бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Даажамбад хүргүүлэв.<br>“Эрдэнэс Монгол” ХХК-иас зөвлөх үйлчилгээний зардалд шаардагдсан 335.8 ам долларын санхүүжилтийг шийдвэрлэсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 14 | 20 | **”Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн талаар** | **ТӨБЗГ – БТУХ** | “Бүрэн | Бүрэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **авах зарим арга хэмжээний тухай,**<br><br>2017-07-04, № 202<br><br>1. ““Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эдгээр компанийн 49 хувийн энгийн хувьцааг төрд шилжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | Засгийн газраас 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн “Хувьцааг төрийн өмчид бүртгэх, холбогдох төлбөрийг суутган тооцох тухай” 07 дугаар тогтоолын 6 дахь заалтын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн өмчид бүртгүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, 100 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаниар улсын бүртгэлд тус тус бүртгүүлсэн.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 7 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн, 6 дугаар тогтоолоор “Монголросцветмет” ХХК-ийн дүрмийг тус тус батлан мөрдүүлж байна. | хэрэгжсэн” – 100 % | хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| | 21 | **”Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай,**<br><br>2017-07-04, № 202<br><br>2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцаанаас Монгол Улсын иргэдэд хувь эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж, хувьцаа эзэмших хөтөлбөр батлан хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцаанаас Монгол Улсын иргэдэд хувь эзэмшүүлэх асуудлаар Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох байгууллагуудтай уулзалт хийж, компанийн баримт материалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А-1/2755 дугаар албан бичгийг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлж, Засгийн газрын 2017 оны 202 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд хийж гүйцэтгэх шаардлагатай ажлуудын талаар мэдээлэл хүргүүлж, чиглэл өгөхийг хүссэн боловч хариу ирүүлээгүй. Иймд “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны тодорхой хэсгийг иргэдэд эзэмшүүлэх тухай асуудлыг боловсруулан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 10 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2018 оны 10 дугаар тогтоолоор тус асуудлыг Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэн зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Улмаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 148 дугаар захирамжийн 2.1 дэх заалтаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцаа эзэмшил, удирдлагын асуудлаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Дэд ажлын хэсэг байгуулан ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасан.<br><br>Мөн Захиргааны хэргийн анхан, давах, хяналтын шатны шүүгчийн шийдвэрээр Засгийн газрын 2017, 2018 оны шийдвэр тогтоол, түүнийг | “Хэрэгжих шатанд” – 70% | 2018 оны 10 дугаар тогтоол гарсан тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар (хуучин нэрээр)-ын шийдвэрийг тус тус илт хууль бус байсан болохыг тогтоож шийдвэрлэсэн тул тогтоолын хэрэгжилтийг хангах ажил удааширч байна. | | |
| 15 | 22 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2017-08-09, № 219<br>1. Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 377,017,720.00 (гурван зуун далан долоон сая арван долоон мянга долоон зуун хорин) төгрөгийн балансын үнэтэй, 82,399,633.13 (наян хоёр сая гурван зуун ерэн есөн мянга зургаан зуун гучин гурван төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн элэгдэл бүхий хавсралтад заасан дөрвөн барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>2 удаа дуудлагын худалдааг зарлаад оролцогч ирээгүй тул худалдах доод үнийг 50 хувь буулгаж дахин зарласан. 2018 оны 7 дугаар сарын 16-нд дуудлагын худалдааг зохион байгуулж, Архангай аймгийн Эрдэнэбулган суманд байрлах Төрийн банкны тооцооны төвийн барилга нь 133,450,000 төгрөгөөр зарагдсан. ТӨБЗГ-ын 2018 оны 10 сарын 16-ны өдрийн хуралдаанаар асуудлыг оруулж хэлэлцүүлэн 439 дүгээр тогтоолоор Өмчлөх эрхийг шилжүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 23 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2017-08-09, № 219<br>2. Дуудлагын худалдааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Төрийн банкны гүйцэтгэх захирал Б.Цэндсүрэн нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Архангай аймгийн Эрдэнэбулган суманд байрлах Төрийн банкны тооцооны төвийн барилгыг худалдан борлуулсны орлого 133,450,000 төгрөгийг Төрийн сан банкин дахь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын данс 100900000721 дугаар дансанд төвлөрүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| 16 | 24 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2017-08-17, № 229<br>2. Үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх ажлыг | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал хэмнэх зорилгоор барилга хүлээлцэх ажлыг холбогдох байгууллагад албан бичиг хүргүүлж, чиглэл өгөн биелэлтийг тооцож ажиллав. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар хамтран дараах хөрөнгийг хүлээлцэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг ирүүлсэн:<br>- Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Жигүүр амралтын газрыг Гаалийн ерөнхий газарт шилжүүлсэн тухай;<br>- Говь-Алтай аймгийн Бургастай боомт дахь болон Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хорооны барилгыг Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлэх тухай.<br>Дорнод аймгийн МСҮТ, Дорнод аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний төв хамтран МСҮТ-ийн оюутны байрыг хүлээлцсэн.<br>БХБЯ, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар Говь-Алтай, Завхан аймгийн Газрын харилцаа, геодези зураг зүйн газарт тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах тухай албан бичиг хүргүүлсний дагуу хамтарсан ажлын хэсэг томилж, үл хөдлөх хөрөнгийг хүлээлцэх ажлыг зохион байгуулсан.<br>Эрүүл мэндийн яамны 2018 оны 5 дугаар сарын 21-ны өдрийн 2/1988 дугаар албан бичгээр Монгол-Солонгосын дорнын анагаах ухааны төвийн барилгыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн тухай мэдээлэл ирүүлснийг хянан баталгаажуулав. | | |
| 17 | 25 | **Хувьцааны хөрөнгө шийдвэрлэх тухай**<br>2017-10-25, № 300<br>3. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн менежментийг сайжруулан үйл ажиллагааг нь дэмжиж, үр ашигтай ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Харилцаа холбооны зохицуулах хороо (С.Адъяасүрэн), Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн менежментийг сайжруулан үйл ажиллагааг нь дэмжиж, үр ашигтай ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авч, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий Сангийн яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулсан.<br>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 1/778 дугаар албан бичгийг “Монголын цахилгаан холбоо” ХК-д хүргүүлж, нийт 5 зөвлөмжийг авч хэрэгжүүлэн 2018 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг үүрэг болгосон. Ажлын хэсэг болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагууд компанийн зүгээс авч хэрэгжүүлсэн хэрэглэгчийн цар хүрээг тэлэх, LTE үйлчилгээг нэвтрүүлэх талаар холбогдох талуудтай хамтран ажиллах, шинээр үйлчилгээний төрөл нэмэх, цахим засгийг нэвтрүүлэх систем хөгжүүлэх зэрэг чиглэлээр хийсэн ажлын үр дүнтэй танилцаж, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар чиглэл өгсөн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18 | 26 | **Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай**<br><br>2017-11-24, № 315<br><br>2. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт, хавсралтад заасан төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг хуульд заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ХААХ**<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д тусгагдсан 835,077.60 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 536 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчидтай хамтарсан тушаалаар батлахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 133 (5 эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ орсон), яамдад 126, нийслэл, орон нутагт 281 төсөл, арга хэмжээ (т.а.х.)-г тус тус зохион байгуулахаар шийдвэрлэсэн.<br><br>ТӨБЗГ-т зохион байгуулах 133 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажиллав.<br><br>Худалдан авах ажиллагааны явцын дүн, 2018.12.26-ны байдлаар:<br>1. Гэрээ байгуулсан – 121 т.а.х. (91.0 %);<br>2. Гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн – 1 т.а.х. (0.8%);<br>3. Үнэлгээ хийж байгаа – 4 т.а.х. (3.0 %);<br>4. Тендер зарласан, нээлт хийх болоогүй – 1 т.а.х. (0.8 %);<br>5. Тендер шалгаруулалт хүчингүй болсон – 5 т.а.х. (3.8 %);<br>6. Захиалагчаас ажлын даалгавар ирүүлээгүй – 1 т.а.х. (0.8 %);<br><br>Дүгнэлт: Нийт зохион байгуулах худалдан авах ажиллагааны 91.0 хувь буюу 121 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж дууссан байна. Үүний үр дүнд 155.9 тэрбум төрөгийн төсөвт өртөг бүхий 121 төсөл, арга хэмжээнд 123.04 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг байгуулж, 32.9 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт гаргасан. Тендер шалгаруулалтын үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –д нийтэлж, олон нийтэд мэдээлсэн.<br><br>Нийт 133 төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолтыг захиалагчаас ирүүлсэн боловч зураг төсөлд өөрчлөлт оруулах болон техникийн тодорхойлолтыг үндэслэн зураг төсөл хийлгэх шаардлагатай шалтгаанаар Зам, тээврийн хөгжлийн яамны-1, Эрүүл мэндийн яамны-1, Барилга хот байгуулалтын яамны -1 төсөл, арга хэмжээний холбогдох материалыг захиалагчид буцаан хүргүүлэв.<br><br>Уг тогтоолын 2 дугаар хавсралтад заасан “Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжих хугацаа дууссан, 2019 онд зохион байгуулах худалдан авах ажиллагаа-ны жагсаалт 2018 оны 388 дугаар тогтоо-лоор батлагд-сан. 2018 оны үлдсэн ажлын үр дүнг дараагийн тогтоолын хэрэгжил-тэд тусган тайлагнах боломж-той. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг Монгол улсад анх удаа, цахим хэлбэрээр зохион байгуулж, 17 багцад эм ханган нийлүүлэгч 10 компанитай давхардсан тоогоор 40 гэрээ байгуулсан бөгөөд 2 дахь шатны нийлүүлэлт амжилттай явагдаж байна. Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авсны үр дүнд 2018 оны жилийн эцсийн дүнгээр улсын төсөвт 325.4 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. | | |
| 19 | 27 | **“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**<br>2017-11-29, № 322<br>3. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийг японы талтай хамтран байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох 49 хувийг эзэмших төрийн өмчит компани байгуулах асуудлыг Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 02, 23-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцсэн. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 150 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох 49 хувийг эзэмших “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулахаар тогтсон. Монголын талын 49 хувийг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг дээрх тогтоолоор томилсон. Хувьцаа эзэмшигчийн хурлаар “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг баталж, гүйцэтгэх захирлыг томилсон.<br>“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийг японы талтай хамтран байгуулах асуудлын хүрээнд Ерөнхий сайдын захирамжаар томилогдсон ажлын хэсэг ажиллаж байна. Хуулийн болон санхүүгийн зөвлөх авч ажиллуулсны үндсэн дээр Концессын гэрээний болон Хувьцаа эзэмшигчийн гэрээний төсөл бэлэн болоод байна. Япон талын консерциум болон “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ХХК-ийн хооронд түншлэлийн гэрээг байгуулсан. Япон тал хамтарсан компанийн 51 хувийг эзэмших хуулийн этгээдийг байгуулаагүй байгаа тул хамтарсан компани байгуулах асуудал удааширч байна.<br>Монголын талын зүгээс ажил зохих шатанд зохион байгуулагдаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 28 | **“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх** | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-тай хамтран | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **арга хэмжээний тухай**<br>2017-11-29, № 322<br>4. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээдтэй хэлэлцээ хийж, холбогдох гэрээний төслийг 2017 оны 12 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | хэрэгжүүлэх Япон Улсын консерциумтай хамтран ажиллах Түншлэлийн гэрээг байгуулсан.<br>Зам, тээврийн хөгжлийн дэд сайдын баталсан “Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулахад Зам, тээврийн хөгжлийн яамны түвшинд авах арга хэмжээний төлөвлөгөө”-нд заасан хугацаанд багтаан Концессын гэрээ, Түншлэлийн гэрээ, Хувьцаа эзэмшигчдийн гэрээг харилцан тохиролцож байгуулахаар ажиллаж байна. ЗТХЯ-ны зүгээс Ерөнхий сайдад тухай бүр явцыг танилцуулан ажиллаж байгаа болно. | | |
| 20 | 29 | **Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль, эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай**<br>2017-12-13, № 337<br>1. Төсвийн сахилга, хариуцлагыг чангатгаж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай: 1.1.Засгийн газраас Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль санаачлахгүй байх зарчим баримталж байгаатай холбогдуулан батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, аливаа өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагаагаа зохион байгуулах; 1.2.төсвийн хууль тогтоомж зөрчин төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өр үүсгэсэн болон тендер шалгаруулалтыг зохион байгуулж | **ТӨБХХ, ЗХЗХ, ХААХ**<br>1.1.ТӨБЗГ-ын 2018 оны үйл ажиллагааны зардалд нийт 1,945.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар 1.882.7 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан. 2018 оны төсвийн гүйцэтгэл 96.8%-тай, 63.2 сая төгрөгийн хэмнэлттэй байна.<br>Төсвийг зориулалтын дагуу зарцуулж байгаа, өр, авлага үүсгээгүй байна.<br>1.2.Тайлангийн хугацаанд, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 32 хуулийн этгээдийн санхүү, эдийн засаг, үйлдвэрлэл үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийт 184.8 тэрбум төгрөгийн зөрчил дутагдал гаргасныг илрүүлсэн. Эдгээр зөрчил дутагдлын 90 хувь нь худалдан авах ажиллагаатай холбоотой байна. Зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай үүрэг чиглэл өгч, биелэлтэд мониторинг хийхээр төлөвлөж байна.<br>1.3.ТӨБЗГ нь арилжааны банкинд жижиг мөнгөн сангийн нэг данстай.<br>1.4.ТӨБЗГ-ын 2018 оны үйл ажиллагааны үр дүнд 46.7 тэрбум төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэв. Үүнд:<br>– Төрийн өмчийн ногдол ашиг - 43.9 тэрбум төгрөг;<br>– Төрийн өмчийн түрээсийн орлого – 2.2 тэрбум төгрөг;<br>– Дуудлага худалдааны орлого – 618.3 сая төгрөг.<br>Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын санд албан хаагчдын цалингаас суутган 94.6 сая төгрөгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу (ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл) төвлөрүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Тайлагнах хугацаа дуусч байгаа тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | үнэлэхдээ холбогдох хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулж, гарсан зөрчлийг тухай бүр залруулж ажиллах; 1.3.арилжааны банк дахь бүх шатны төсвийн байгууллагын цалингийн болон жижиг мөнгөн сангийн данснаас бусад дансыг хааж, төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлэх, гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн арилжааны банк дахь дансыг төрийн сангийн нэгдсэн дансанд шилжүүлж, цаашид төсвийн байгууллага арилжааны банкинд шинээр данс нээхгүй байх, төсвийн аливаа мөнгөн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан удирдаж, мөнгөн хөрөнгийн ашиглалтыг сайжруулан үр ашгийг нэмэгдүүлэх; 1.4.улс, орон нутгийн төсөв, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр сар, улирлын хуваарийн дагуу жигд хангаж биелүүлэхэд онцгой анхаарч ажиллах; 1.5.Улсын Их Хурлаас 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон 2018 оноос хэрэгжиж эхлэх татварын хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулах; 1.6.төсвийн байгууллагын төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулахдаа Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, | 1.5.Дурдсан хуулийг судлан холбогдох заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна.<br><br>1.6.Төсвийн Ерөнхийлөн захирагчид сар бүр төсвийн урсгал зардлын санхүүжилт, гүйцэтгэлийг тайлагнаж, нэгтгэлд тусгуулж байна.<br><br>1.7.а/. Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтын дагуу ТӨБЗГ-т 138 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар байсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зураг төсөв, ажлын даалгавар, техник, эдийн засгийн үндэслэлийг ТӨБЗГ-т яаралтай ирүүлэх асуудлаар нийт 7 удаагийн албан бичгийн холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлж ажилласан. 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар БОАЖЯ-ны 7 төсөл, арга хэмжээнээс бусад 131 төсөл, арга хэмжээний буюу 94.1 хувийн нь холбогдох материал ирээгүй байсан болно. 2018 оны 12 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 133 төсөл, арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолтыг захиалагчаас бүрэн ирүүлсэн болович зураг төсөлд өөрчлөлт оруулах болон техникийн тодорхойлолтыг үндэслэн зураг төсөл хийлгэх шаардлагатай шалтгаанаар Эрүүл мэндийн яамны 2, Барилга хот байгуулалтын яамны 1 төсөл, арга хэмжээний холбогдох материалыг захиалагчид буцаан хүргүүлээд байна.<br><br>б/ТӨБЗГ-т худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардагдах төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг холбогдох материалыг төсвийн ерөнхийлөн захирагчаас хуулийн хугацаанд ирүүлээгүйн улмаас тендер шалгаруулалт мөн хугацаагаар хойшилсон. 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна. 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ТӨБЗГ-т 35 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт дуусч, нийт ажлын 25 хувьд нь гэрээ байгуулж байсан. Жилийн эцсийн дүнгээр нийт 133 төсөл, арга хэмжээнээс 121 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуссан бөгөөд худалдан авах ажиллагааны явц 91.0 хувийн гүйцэтгэлтэй байна.<br><br>в/ Тус газар 2018 онд 133 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр (www.tender.gov.mn) зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлсэн.<br><br>г/. ТӨБЗГ-т 2018 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад бараа худалдан авах 10 (эмнэлэгийн тоног төхөөрөмж) төсөл байгаа бөгөөд захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолт, | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг мөрдөж ажиллах; 1.7.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх: а/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.4-т заасан төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техник, эдийн засгийн үндэслэлийг 2018 оны 1 дүгээр сарын 10-ны дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх; б/ улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг улирлын шинж чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлсэн байх; в/ худалдан авах ажиллагааг цахимаар (tender.gov.mn) зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх; г/ бараа худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа үндэсний үйлдвэрлэлийн барааг импортоор ирж байгаа бараанаас тусад нь багцлан зохион байгуулах; д/ төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрийн төсвийн багцад хамаарах бүх харьяа байгууллагуудын 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн 2018 оны 1 дүгээр сарын | барааны жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн тусгагдаагүй болно.<br><br>д/ ТӨБЗГ-ын 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А-1/111 дугаар албан бичгээр СЯ-нд хүргүүлсэн. 2018 оны жилийн эцсийн тайлан, мэдээг тайлагнахаар бэлтгэж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 15-ны өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлэх. | | | |
| | 30 | **Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн 2018 оны Төсвийн тухай хууль, эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай**<br><br>2017-12-13, № 337<br><br>5. “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр хэрэгжүүлж, анги дүүргэлт хэт өндөр байгаа сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулах, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2018 оны 2 дугаар сард багтаан хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2018 онд ашиглалтад оруулах сургууль, цэцэрлэгийн барилгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, аймаг, нийслэлийн Засаг дарга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ХААХ**<br><br>“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрт хамрагдсан барилга байгууламжийн ажлын худалдан авах ажиллагааг харьяаллын дагуу орон нутгийн худалдан авах ажиллагаа хариуцсан алба, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, БСШУСЯ болон ТӨБЗГ-т тус тус хэрэгжүүлсэн.<br><br>БСШУ-ны сайдын багцаас санхүүжигдэн хэрэгжих 60 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулсан. Эдгээрээс цэцэрлэг шинээр барих 25, засвар хийх 3 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас тайлант хугацаанд уг худалдан авах ажиллагаа бүрэн дуусч, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан үр дүнтэй байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 21 | 31 | **Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2018-01-03, № 2<br><br>2. Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид олгох зээл, зээлийн хүүг газрын тос | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Засгийн газрын 2018 оны 02 дугаар тогтоолоор “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх талаар хэлэлцээ хийхийг ТӨБЗГ-т зөвшөөрсний дагуу холбогдох тооцоо судалгааны үндсэн дээр 250.0 тэрбум хүртэлх төгрөгийн зээлийн гэрээ хийх зөвшөөрлийг ТӨБЗГ-ын 2018 оны 09 дүгээр тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-д олгов.<br><br>Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан “Монгол | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Төрийн өмчийн хувьцааг эзэмших эрх УУХҮЯ-нд шилжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | боловсруулах үйлдвэр ашиглалтад орж, үйл ажиллагаа эхэлсэн үеэс тооцож төлөх талаар Монгол Улсын Хөгжлийн банктай хэлэлцээ хийж, гэрээ байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай | газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид олгох зээл, зээлийн хүүг газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орж, үйл ажиллагаа эхэлсэн үеэс тооцож төлөх талаар Монгол Улсын Хөгжлийн банктай “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК хэлэлцээ хийж, 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ЗГ-МГТ-3 2018-43 дугаар бүхий 4 талт гэрээ байгуулсан. Тус гэрээг талууд хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 323 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг тогтоосон. | | |
| | 32 | **Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2018-01-03, № 2<br><br>3. Төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай)-ын ажлыг 2018 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх арга хэмжээ авч, явц, үр дүнгийн талаар Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын шавыг тавьж, 20 км төмөр зам, 20 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 20 км авто зам барих ажлыг тус тус эхлүүлсэн бөгөөд дараах ажлуудыг гүйцэтгээд байна:<br><br>-Дорноговь аймгийн Алтанширээ суманд Газрын тос боловсруулах үйлдвэр барихаар 150 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авсан.<br><br>-Сайншандаас газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх 20 км салаа төмөр зам, хүнд даацын тусгай зориулалтын автозам, эрчим хүч дамжуулах шугам зэргийг төрийн өмчит компани, байгууллага хариуцаж гүйцэтгүүлэхээр холбогдох яамдын сайд нарт үүрэг өгсөний дагуу БХЯ, БХБЯ, ЗТХЯ-тай гэрээ байгуулан ажиллаж байна.<br><br>-Бүтээн байгуулалтын томоохон ажлын үе шат бүрт Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг байгууллагын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг байнгын хяналт тавин ажиллаж байна.<br><br>-“Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” чиглэлийн хүнд даацын авто зам нь 21,1 км урт бөгөөд 2 (Б) зэрэглэлийн тусгай зориулалтын замын бүтээн байгуулалтын ажил.<br><br>-Авто замын барилга угсралтыг Батлан хамгаалах яамны Замын 7780-р анги нийт 220 хүн, 50 машин механизмтайгаар гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл одоогоор 30 хувьтай байгаа бөгөөд нийт замын уртад 23 ш хиймэл байгууламж хийхээр төлөвлөсөн.<br><br>-Газрын тос боловсруулах үйлдвэрийн байршлыг Сайншанд өртөөтэй холбох салбар төмөр зам нь 27 км урт, жилд үйлдвэрийн хэрэгцээний 1,53 сая тонн ачаа тээвэрлэх зориулалттай, IV зэрэглэлийн зам юм. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | ЗГ-ын 2018 оны 323 дугаар тогтоо-лоор төрийн өмчийн хувьцааг эзэмших эрхийг эзэмшиг-чээр УУХҮЯ-ыг тогтоосон тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | -“УБТЗ” ХНН нийт 279 хүний бүрэлдэхүүнтэй, 94 машин механизмтайгаар газар шорооны ажлыг гүйцэтгэж байна. Төмөр замын нийт трассын дагуу 17 цэгт дөрвөлжин хоолой төлөвлөгдсөн. 27 км төмөр замын нийт уртад замын чиг сэргээх ажил хийгдсэн. Нийт ажлын гүйцэтгэл 30 орчим хувьтай байна.<br>-“ЦДҮС” ТӨХК нь “Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц”-ын барилга угсралтын ажлыг 2018 оны 08 дугаар сарын 20-ний өдрөөс эхэлсэн бөгөөд 2018 оны 10 дугаар сарын 30-нд гүйцэтгэж дуусах төлөвлөгөөтэй ажиллаж байна. “Эрчим хүч, эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ нь зураг төслийн ажлыг гүйцэтгэж, “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨХК нь ЦДАШ, дэд станцын барилгын хяналтын ажлыг гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 95 хувьтай ба өнөөдрийн байдлаар 39 хүний бүрэлдэхүүнтэй 3 бригад, 15 техниктэйгээр ажлаа гүйцэтгэж байна.<br>Бүтээн байгуулалтын ажлын явцыг холбогдох чиглэлийн яамд хариуцан Засгийн газарт танилцуулж байна. | | |
| 22 | 33 | **Хувьцааг төрийн өмчид бүртгэх, холбогдох төлбөрийг суутган тооцох тухай**<br>2018-01-04, № 7<br>6. “Эрдэнэт Үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн өмчид бүртгэн авах арга хэмжээг зохион байгуулахыг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүү, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Эрдэнэт Үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 49 хувийн энгийн хувьцааг төрийн өмчид бүртгүүлэх авах арга хэмжээг хэрэгжүүлж, 100 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаниар улсын бүртгэлд бүртгүүлсэн.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 7 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн, 6 дугаар тогтоолоор “Монголросцветмет” ХХК-ийн дүрмийг тус тус батлан мөрдүүлж байна.<br>Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 10, 11 дүгээр тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилон 100 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн статустай ажиллуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 23 | 34 | **“Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны тодорхой хэсгийг иргэдэд эзэмшүүлэх тухай**<br>2018-01-10, № 10<br>1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцаанаас Монгол Улсын иргэдэд хувь эзэмшүүлэх асуудлаар Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох байгууллагуудтай уулзалт хийж, компанийн баримт материалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А-1/2755 дугаар албан бичгийг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлж, Засгийн газрын 2017 оны 202 дугаар тогтоолыг | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | үйлдвэрийн газрыг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах, нийт хувьцааны тодорхой хувийг Монгол Улсын нийт иргэдэд эзэмшүүлэх асуудлыг боловсруулан Засгийн газарт оруулж хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | хэрэгжүүлэхэд хийж гүйцэтгэх шаардлагатай ажлуудын талаар мэдээлэл хүргүүлж, чиглэл өгөхийг хүссэн боловч хариу ирүүлээгүй. Иймд “Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны тодорхой хэсгийг иргэдэд эзэмшүүлэх тухай асуудлыг боловсруулан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 10 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2018 оны 10 дугаар тогтоолоор тус асуудлыг Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэн зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Улмаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 148 дугаар захирамжийн 2.1 дэх заалтаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцаа эзэмшил, удирдлагын асуудлаар санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Дэд ажлын хэсэг байгуулан ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасан.<br><br>Мөн Захиргааны хэргийн анхан, давах, хяналтын шатны шүүгчийн шийдвэрээр Засгийн газрын 2017, 2018 оны шийдвэр тогтоол, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар /хуучин нэрээр/-ын шийдвэрийг тус тус илт хууль бус байсан болохыг тогтоож шийдвэрлэсэн тул тогтоолын хэрэгжилтийг хангах ажил удаааширч байна. | | |
| 24 | 35 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай**<br><br>2018-01-10, № 8<br><br>1. “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дараах зарчмыг баримтлан Засгийн газрын гишүүд болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын саналыг авсны үндсэн дээр боловсруулж, 2018 оны I улиралд багтаан танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай:<br><br>1.1. олон нийтийн оролцоог хангах, хяналтын тогтолцоог төлөвшүүлэх, компанийн засаглалыг сайжруулах, | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг холбогдох яам болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын саналыг авсны үндсэн дээр боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Уг төсөлд нийт 18 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 19 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 37 хуулийн этгээдийг хувьчлах талаар тусгагдсан. Дээрх тогтоолын төсөл бүхий саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр Улсын Их Хуралд өргөн барьсан. Улсын Их Хурал тус саналыг хэлэлцээд, Эдийн засгийн байнгын хорооны дэргэд ажлын хэсэг байгуулан зарим судалгаа тооцоог хийх чиглэл өгсний дагуу ажлын хэсэг судалж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, техник, технологийг шинэчлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх, төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг хөрөнгийн биржээр арилжаалах;<br>1.2. хувийн хэвшилд суурилсан зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих бодлого баримталж, үйлдвэрлэл, үйлчилгээний салбар дахь төрийн оролцоог бууруулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн өмчит зарим хуулийн этгээдийг хөрөнгийн биржээр болон нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлах. | | | |
| | 36 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай**<br>2018-01-10, № 8<br>2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үр ашгийг дээшлүүлэх талаар дараах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай: 2.1.компанийн засаглалыг сайжруулж, ил тод, нээлттэй байдлыг хангах, үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бий болгох; 2.2.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга | **ТӨБЗГ – БТУХ**<br>2.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой нийт 96 хуулийн этгээдийн 2017 оны жилийн эцсээрх болон 2018 оны хагас жилийн байдлаарх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдалд аудит хийсэн. Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй нийт 8 хуулийн этгээдэд цаашид шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлэх, мэдээ тайлангаа хуульд заасан хугацаанд бүрэн оруулах, байгууллагын өөрийн цахим хуудас дахь шилэн дансны цэсээ тогтмол шинэчлэн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллах талаар ТӨБЗГ-ын даргын 2018 оны А-1/2135-2141 дугаар албан бичгийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төрийн өмчийн ашиглалт, хяналтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглал, нийгмийн хариуцлагыг олон нийтэд сурталчлах зорилгоор “Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2018” өдөрлөгийг 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Уг өдөрлөгт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 75 хуулийн этгээд оролцож, 2017 онд гаргасан эдийн засгийн эерэг үзүүлэлт, гаргасанололт амжилтаа олон нийтэд сурталчлав. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэмжээ авч байх; 2.3.удирдлага, менежментийг сайжруулах, үргүй зардлыг багасгах зорилгоор төрийн өмчит зарим хуулийн этгээдийг нэгтгэх, татан буулгах, өөрчлөн зохион байгуулах; 2.4. төрийн өмчийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, түүнийг дүгнэх аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлан мөрдүүлэх; 2.5.компанийн удирдлага, ажиллагсдын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, төрд төлсөн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлал гаргаж мөрдүүлэх; 2.6.өр, авлага болон дамжуулан зээлдүүлэх гэрээний хүүг бууруулах талаар тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авах; 2.7.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулж, дотоодын үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг тэргүүн ээлжинд авах боломжийг бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. | 2.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/350 дугаар албан бичгээр “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх” талаар албан даалгавар хүргүүлсэн. Албан даалгаврын хэрэгжилттэй газар дээр нь танилцах, биелэлтийг ирүүлээгүй хуулийн этгээдүүдтэй хариуцлага тооцох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна.<br><br>2.3.Мөн алдагдалтай ажиллаж байгаа, санхүүгийн зохистой харьцаа алдагдсан хуулийн этгээдийн үйл ажиллагааг сайжруулах, өөрчлөн зохион байгуулах зорилгоор ажлын хэсэг томилон ажиллууж, хуулийн этгээд бүрд үнэлэлт дүгнэлт өгсөн. Төрийн өмчит зарим хуулийн этгээдийн удирдлага, менежментийг сайжруулах, үргүй зардлыг багасгах зорилгоор төрийн өмчит зарим хуулийн этгээдийг нэгтгэх, татан буулгах, өөрчлөн зохион байгуулах саналыг Засгийн газарт хүргүүлж, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай” 9 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлсэн. Уг тогтоолоор Алдагдалтай ажиллаж байсан болон үйл ажиллагаа нь зогссон “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК, “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК, “Монгол тамга” ТӨҮГ, “Монгол тариалан” ТӨҮГ, “Монгол мах” ТӨҮГ-ыг тус тус татан буулгасан.<br><br>2.4.Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захиралтай байгуулах контрактын загвар, төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах контрактын загварт өөрчлөлт оруулан, гүйцэтгэх захирал, захирлуудтай гэрээ байгуулав.<br><br>2.5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн “Урамшуулал олгох тухай” 323 дугаар тогтоолоор контрактын биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн нийт 46 хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралд олгох урамшууллын хэмжээг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу тогтоосон. Тус тогтоолын дагуу захирал, гүйцэтгэх захирлуудад урамшууллыг олгосон.<br><br>2.6.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага, өглөгийг бууруулах талаар арга хэмжээ авч ажилласны дүнд 2018 онд авлага 472.8 тэрбум төгрөг болж, 2017 оны гүйцэтгэлээс 13.3 тэрбум төгрөгөөр буюу 2.8 хувиар, өр төлбөр 3583.6 тэрбум төгрөг болж, 48.5 | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тэрбум төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан.<br><br>2.7. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://tender.gov.mn –ийг хариуцан ажиллаж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод болгох ажлыг зохион байгуулан хяналт тавин ажиллаж байна. | | |
| | 37 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай**<br><br>2018-01-10, № 8<br><br>3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг дүгнэж, цаашид уг асуудлаар өөрчлөлт, шинэчлэл хийх, хувьчлах байгууллагын талаар санал боловсруулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт, эдгээр саналыг нэгтгэх замаар 2018-2020 онд нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл хийх, хувьчлах байгууллагын жагсаалт гарган танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>“Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, цаашид тус салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх саналыг боловсруулан Засгийн газарт танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг Ерөнхий сайдын 2018 оны 66 дугаар захирамжаар байгуулагдсан. Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл”, Засгийн газрын 2003 оны 34 дүгээр тогтоолын хэрэгжилт, биелэлтийг Ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн болно. Ажлын хэсгийн даргаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар томилогдсон бөгөөд дарга хурлын товыг зарлан хуралдуулах хүртэл бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 38 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай**<br><br>2018-01-10, № 8<br><br>4. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хэрэгцээ, шаардлагагүй барилга, байгууламж, эд | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>Хэрэгцээ шаардлагагүй барилга байгууламж, эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн талаар 2017 оны жилийн эцсийн тайлан мэдээ авах үеэр буюу 2018 оны 3 дугаар сард судалгаа авсан бөгөөд худалдан борлуулах хөрөнгийн санал ирүүлээгүй болно. Харин зарим барилга байгууламжийг балансаас балансад шилжүүлэх санал ирүүлснийг Засгийн газарт хүргүүлэн тухай бүр шийдвэрлүүлж байна.<br><br>Элэгдлээрээ анхны үнийг бүрэн нөхсөн үлдэх өртөггүй, сэргээн | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн, тайлант хугацаа дууссан тул хяналтаас хасах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хөрөнгө, тоног төхөөрөмжийг судлан худалдан борлуулах санал боловсруулж 2018 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | засварлах боломжгүй, эсвэл сэргээн засварлахад эдийн засгийн хувьд зардал өндөртэй автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэв. 2018 онд 67 байгууллагын 253 автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж, 618.3 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэв. | | саналтай. |
| | 39 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай**<br>2018-01-10, № 8<br>5. Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогод хамрагдсан нийт 729 нэрийн 1,131.0 (нэг их наяд нэг зуун гучин нэгэн) тэрбум төгрөгийн дуусаагүй барилга байгууламж (зураг төсөв)-ийг үргэлжлүүлэн санхүүжүүлж дуусгах, хувьчлах, худалдах асуудлыг судлан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж шийдвэрлүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Тооллогын дүнгээр судалгааг нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлсэн бөгөөд шийдвэрлүүлэх асуудлаар ЗГХЭГ-аас Сангийн яаманд чиглэл өгсөн.<br>ТӨБЗГ-ын зүгээс тооллогын дүнгээр гаргасан дээрх судалгааг илүү дэлгэрэнгүй, ойлгомжтой болгох үүднэс Нийслэлийн өмчийн харилцааны газар, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газартай хамтран дуусаагүй барилга бүрийн талаар фото зураг, гүйцэтгэгч, захиалагч, санхүүжүүлэгч байгууллагын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй гаргуулан авч, нэгтгэн Сангийн яамны Хөрөнгө оруулалтын газарт цахим хэлбэрээр хүргүүлсэн.<br>Орон нутгийн өмчид бүртгэлтэй дуусаагүй барилгыг үргэлжлүүлэн дуусгах, нэмэлт санхүүжилт хийх эсхүл худалдах асуудлыг аймгуудын ОНӨГ-аас хариуцан боловсруулж, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулан шийдвэрлүүлж байгаа.<br>Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй дуусаагүй барилгыг үргэлжлүүлэн санхүүжүүлэх асуудлыг Сангийн яамнаас Улсын төсвийн тухай хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай |
| 25 | 40 | **Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай**<br>2018-01-10, № 9<br>2. Хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай нь хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулж гүйцэтгэлийг тайлагнахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Тус тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар татан буулгах 4 комисс байгуулагдан хууль тогтоомжийн дагуу ажиллаж байна:<br>-“Монгол тамга” ТӨҮГ-ын захирал байсан Д.Рэнцэнтавхай нь ажиллах хугацаандаа байгууллагын хөрөнгөөс хувьдаа авч ашигласан нийт 126,489,828 төгрөгийг гаргуулж, татан буугдаж байгаа байгууллагыг хохиролгүй болгох асуудлаар Сүхбаатар, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандсан.<br>-“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийг татан буулгах үүрэг бүхий Ажлын хэсэг уг компанийн 6.9 сая төгрөгийн авлагыг авч, 206.5 сая төгрөгийн өглөгийг барагдуулж ажилласан. Мөн Үндэсний архивын газарт компанийн архивын бичиг баримтыг хүлээлгэн өгсөн.<br>-“Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК-ийн татан буулгах комисс иргэд, аж | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ахуйн нэгжүүдээс тогтоосон хугацаанд өргөдлийг хүлээн авах, өр төлбөрийн мэдээллийг нэгтгэх, "БООБШ" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн удирдлага, ажилтнуудаас компанийн эд хөрөнгийг жагсаалтаар хүлээн авч акт үйлдэх зэрэг ажлуудыг хийв. Хүлээн авсан эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах асуудлыг хэлэлцэхээр ажиллаж байна.<br>-"Монгол тариалан корпораци" ТӨҮГ, "Монгол мах корпораци" ТӨҮГ-тай өр, авлагын тооцоотой хувь хүн, хуулийн этгээдтэй тооцоо нийлэх, баталгаажуулалт хийх ажлыг зар, мэдээлийн дагуу зохион байгуулав. Зарласан хугацаанд ямар нэгэн хүсэлт, гомдол ирээгүй байна. | | |
| | 41 | **Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай**<br>2018-01-10, № 9<br>4. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулсан, өөрчлөн байгуулсан шийдвэрийг хүчингүй болсонд тооцохыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Цагдаагийн ерөнхий газрын дарга С.Баатаржавт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Татан буугдсан "Авто замын тоног төхөөрөмжийн түрээс" ТӨХК, "Аж үйлдвэрийн цогцолбор" ТӨХК, "Монгол тамга" ТӨҮГ, "Монгол тариалан" ТӨҮГ, "Монгол мах" ТӨҮГ-ыг байгуулсан, өөрчлөн байгуулсан шийдвэрийг тус тус хүчингүйд тооцон ажиллаж байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 26 | 42 | **Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай**<br>2018-01-24, № 21<br>2. Төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 143 дугаар тогтоолоор "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн төмөр замын салбар зам, хүнд даацын тусгай зориулалттай авто замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажил, барилгын ажлын техник, технологийн байнгын хяналтыг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-т хариуцуулж, хяналтын тогтолцоог бий болгосон.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд тавьсан хяналтын талаар "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-аас хагас жил тутамд тайлан, мэдээг аван дүгнэлт хийж байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | Төрийн өмчийн хувьцаа эзэмших эрх УУХҮЯ-нд шилжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 27 | 43 | **Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2018-01-31, № 31<br>2. Үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх ажлыг | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 6 давхар барилгыг Хөдөлмөр, халамжийн | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | үйлчилгээний ерөнхий газарт албан конторын зориулалтаар балансаар балансад шилжүүлэх ажлыг гүйцэтгэв. Уг үл хөдлөх хөрөнгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар балансад бүртгэж авсан энэ тухайгаа 2018 оны 1/158 дугаар албан бичгээр хариу мэдэгдсэн байна. | | саналтай. |
| 28 | 44 | **2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарлах тухай**<br>2018-01-31, № 32<br>2.1."Хариуцлагын жил"-ийн хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулж тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан дүгнэж ажиллах; | **ТӨБЗГ - ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 8 заалттайгаар батлан хэрэгжилтийг 100 % хангасан. Тус төлөвлөгөөний хүрээнд ТӨБЗГ-ын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, шинэ мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг 32 удаа зохион байгуулсан бөгөөд иргэд, олон нийтээс ирсэн 224 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, ажлын байрны давхардлын судалгааг хийж, албан хаагчдын цаг ашиглалтыг сайржуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайланг сар бүр ЗГХЭГ-т хүргүүлэн ажилласан.<br>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамтаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлж хэвшсэн.<br>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ТӨБЗГ-т хамаарал бүхий нийт 18 арга хэмжээний 2018 оны зорилтот түвшингийн хэрэгжилт 2018 оны эхний хагас жилийн дүнгээр 78.8 хувийн үнэлгээтэй байна.<br>Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд ТӨБЗГ-т хамаарал бүхий 4 зорилт, арга хэмжээ тусгагдсан бөгөөд түүний хэрэгжилт хагас жилийн дүнгээр 85.0 хувийн үнэлгээтэй байна.<br>Дээрх тайлангуудын 2018 оны жилийн эцсийн дүнг гаргах зохион байгуулалтын арга хэмжээ авсан, тайланг гаргаж, холбогдох журамд заасан хугацаанд ЗГХЭГ, СЯ-нд хүргүүлэхээр бэлтгэж байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| | 45 | **2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарлах тухай** | **ТӨБЗГ - ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>2018 онд ТӨБЗГ-т нийт 240 өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авснаас | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2018-01-31, № 32<br><br>2.2. яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэлбэрэлтгүй биелүүлж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авах; | шийдвэрлэсэн 224, хяналтад 5, хугацаа хэтэрсэн, шийдвэрлэгдээгүй 11 (ЗХЗХ-1, БТУХ-9, ТӨБХХ-1) өргөдөл, гомдол байна. ТӨБЗГ нь өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд 2017 оны жилийн эцэс, 2018 оны I, II, III улирлын шийдвэрлэлтийн тайланг газрын www.pcsp.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн ТӨБЗГ-ын 2018 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээллийг III улирлын байдлаар гарган ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br><br>Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан 2018 онд нийт 20 санал, хүсэлт, гомдол ирүүлснийг бүртгэлд хамруулан шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллав. Тэдгээрээс орон нутагт зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагаатай холбоотой 9, худалдан авах ажиллагааны системтэй холбоотой 3, худалдан авах ажиллагааны талаар сургалт явуулах тухай 1, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой 1, газрын албан хаагчтай холбоотой 2, газар эзэмших эрхтэй холбоотой 1, өмчтэй холбоотой 2, лавлагаатай холбоотой 1 санал, хүсэлт, гомдол байна. Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх хүрээнд асуудлыг шуурхай нягтлан шалгаж, удирдлагын заалтын дагуу холбогдох албан хаагчдад шилжүүлэн, шийдвэрлэлтэд нь бүртгэлээр хяналт тавин ажиллав. Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан асуудлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгсөн байна. ТӨБЗГ-ын албан хаагчтай холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх хүрээнд 1 албан хаагчийн асуудлыг ТӨБЗГ-ын “Ёс зүйн хороо”-оор хэлэлцэн, сануулга өгч, бусад албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн.<br><br>2018 онд “Нэг цэгийн үйлчилгээ”-гээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад давхардсан тоогоор нийт 23312 үйлчилгээг үзүүлсэн байна. Үйлчилгээний тоон үзүүлэлтийг харуулбал:<br><br>– Зөвлөгөө өгсөн - 15299 (утсаар 8663, биечилж 6636);<br>– Тендертэй холбоотой мэдэгдэл, тодруулга, саналын урилга хүргэсэн - 1203;<br>– Цахим гарын үсгийн Е-токен код олгосон - 55;<br>– А3 сертификат олгосон - 2269;<br>– Онлайн асуултад хариулсан - 603 байна<br>– Тендер оролцох хүсэлтэй ААН-ийн цахим системд бүртгэн баталгаажуулсан - 3883.<br><br>Газрын www.tender.gov.mn цахим хуудсанд нийтлэг асуулт, хариултын булан (online chat) нээж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хүрэх | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн шуурхай хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлсэн. | | |
| | 46 | **2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай**<br>2018-01-31, № 32<br>2.3. төрийн захиргааны бүх шатны байгууллага ажиллагсадтайгаа байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллаж байх; | **ТӨБЗГ - ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь албан хаагчидтай төрийн алба хаагчийн үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээг жил бүр байгуулж, хагас, бүтэн жилээр дүгнэн, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлж хэвшсэн.<br>2018 онд 82 (давхардсан тоогоор) албан хаагчтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулсан. 2018 оны эхний хагас жилд 67 албан хаагчийн үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэв. Үүнээс: 39 (58%) - А буюу маш сайн , 22 (33%) - В буюу сайн, 5 (8%) - С буюу хангалттай, 1(1%) - D буюу дутагдалтай үнэлэгдсэн. 2018 оны жилийн эцсээр 72 албан хаагчийн үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэв. Үүнээс: 64 (89%) - А буюу маш сайн, 7 (10%) - В буюу сайн, 1 (1%) - С буюу хангалттай үнэлгээтэй байна.<br>Тайлант онд, ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажлын цагийг үр бүтээлгүй ашигласан 2 албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 47 | **2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай**<br>2018-01-31, № 32<br>2.4. 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан төсөл, арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрэгжүүлж ажиллах; | **ТӨБЗГ – ХААХ**<br>ТӨБЗГ-ын 2018 онд хэрэгжүүлэх 133 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдан ажиллав. Нийт 121 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж дууссан, худалдан авах ажиллагааны явц 91.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүний үр дүнд, 2018 оны жилий эцсийн байдлаар 155.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 121 төсөл, арга хэмжээнд 123.04 тэрбум төгрөгийн гэрээ байгуулагдсанаар 32.9 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт гаргасан дүнтэй байна.<br>Тендер шалгаруулалтын үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn–д нийтэлж, олон нийтэд мэдээлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Тайлагнах хугацаа дууссан тул хяналтаас хасах саналтай. |
| | 48 | **2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай**<br>2018-01-31, № 32<br>2.5. “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1 | **ТӨБЗГ - ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 8 заалттайгаар боловсруулан 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр батлан, хэрэгжилтийг хангав. ТӨБЗГ-ын даргын 2018 оны А/240 дүгээр тушаалаар сахилга хариуцлагыг | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах. | чангатгах талаар Засгийн газраас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулав.<br><br>Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Төрийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн 2 албан хаагчийн асуудлыг байгууллагын Ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлж, Төрийн албаны тухай хуулийн дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулсан. Эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан 6 албан хаагчтай холбоотой асуудлаар сонсох ажиллагаа хийж, цаашид алдаа дутагдал гаргахгүй байх талаар анхааруулав.<br><br>Төрийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн 2 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулсан.<br><br>Төрийн холбооны газартай хамтран интернетийн олон нийтийн сүлжээ (facebook, twitter)-д албаны компьютерээс хандах боломжгүй болгож холбогдох тохиргоог 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хийж, интернетийн зохистой хэрэглээг хангах, албан хаагчдын ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авав.<br><br>Засгийн газрын 2018 оны “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагад интернетийн зохистой хэрэглээг бий болгох арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол, 16 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, харьяа төрийн өмчит хуулийн этгээдэд уг тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А-1/2160 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, ажлын цагаар нийгмийн цахим сүлжээг ашиглахгүй байх хязгаарлалт хийв. | | |
| | 49 | **2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай**<br><br>2018-01-31, № 32<br><br>3. “Хариуцлагын жил”-ийн хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж бүр компанийн засаглалыг хэрэгжүүлэн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шинэ шатанд гарган ажиллах арга хэмжээ авсугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд хариуцлагатай ажиллах, нийгмийн хариуцлагын бодлого гаргаж хэрэгжүүлэх чиглэл өгөн ажиллаж байна. Цаашид төрийн өмчит хуулийн этгээдүүд салбарын онцлог, бизнесийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарч тухайн чиглэлийн хувийн хэвшлийн байгууллага, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран ажиллана. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид чиглэл өгч, удирдлагаар хангадаггүй болно. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”–ХБ. | Хэрэгжих боломж-гүй тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 29 | 50 | **Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн тухай**<br><br>2018-01-31, № 34<br><br>1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай: 1.1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ижил хүчин чадал бүхий төслүүдийг нэг маягийн зургаар хэрэгжүүлж төсөвт өртгийн зөрүүг багасгах; 1.2. нэг маягийн зургаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний холболтын зураг төсөв хийлгэх ажлыг яаралтай зохион байгуулж, нэг маягийн зураггүй төслүүдийг ойролцоо байршил, хүчин чадал бүхий нэг маягийн зурагт холболтын зураг, төсөв хийлгэж хэрэгжүүлэх; 1.3. нэг маягийн зургаар хэрэгжүүлэх боломжгүй төсөл, арга хэмжээний зураг, төсвийг шинээр боловсруулахад шаардагдах зардлыг барилгын ажил гүйцэтгэх гэрээний дүнд оруулан, 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөгт багтаан санхүүжүүлэх. | **ТӨБЗГ – ХААХ**<br><br>Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2018 онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээний зураг төсөв нь бэлэн болоогүй барилга байгууламжийн ажлын худалдан авах ажиллагааг захилагчаас ирүүлсэн нэг маягийн зураг, түүний холболтын зургийн дагуу зохион байгуулж ажилласан.<br><br>Нэг маягийн зургаар хэрэгжүүлэх боломжгүй төсөл, арга хэмжээний зураг, төсвийг шинээр боловсруулахад шаардагдах зардлыг барилгын ажил гүйцэтгэх гэрээний дүнд оруулан "Түлхүүр гардуулах гэрээ"-ний нөхцөлтэйгөөр худалдан аавах ажиллагааг зохион байгуулсан болно.<br><br><u>Тэмдэглэл:</u> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ" гэж заасан тул төсвийн ерөнхийлөн захирагчид хуулиар олгосон худалдан авах ажиллагааны талаарх эрх, үүрэг ТӨБЗГ-т хамааралгүй болно. | "Бүрэн хэрэгжсэн" – 100%. | МУ-ын 2018 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүү-лэхтэй холбоо-той, төсвийн жил дууссан, бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 30 | 51 | **Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2018-02-06, № 43<br><br>1.4. улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр баригдсан бөгөөд бүрэн ашиглалтад оруулж чадаагүй "ДЦС-2" ТӨХК-ийн дэргэдэх сайжруулсан түлшний үйлдвэрийг түшиглэн | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>"Дулаан цахилгаан станц-2" ТӨХК-ийн дэргэдэх сайжруулсан түлшний үйлдвэрийг түшиглэн нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр хангах бие даасан "Таван толгой түлш" компани байгуулагдсан. "Таван толгой түлш" ХХК-ийг байгуулан ажиллуулж байна. Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 387 дугаар тогтоолоор Таван толгой түлш" ХХК-ийн талаар зарим арга хэмжээг авч шийдвэрлэсэн. Тухайлбал, уг компанийн төрийн | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр хангах бие даасан аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газрыг байгуулах асуудлыг судалж, саналаа 2018 оны 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т; | эзэмшлийн хувьцаа эзэмших эрхийг хэрэгжүүлэгчээр УУХҮЯ, ЭХЯ, ТӨБЗГ-ыг тогтоосон байна. Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээг хувьцаа эзэмшигч болон ТУЗ-тэй хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. | | |
| 31 | 52 | **Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай**<br>2018-02-14, № 51<br>2. Төрийн зарим чиг үүргийг "Барилгын хөгжлийн төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэхээр болсонтой холбогдуулан уг газрын дүрмийг шинэчлэн баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 85 дугаар тогтоолоор "Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсан.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас үйлдвэрийн газрын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг нэгтгэн хяналт тавин ажиллаж байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 32 | 53 | **Орон сууц хувьчлах тухай**<br>2018-03-27, № 78<br>2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн тогтоолоор Булган аймгийн орон сууц хувьчлах товчоог байгуулах шийдвэр гаргасан. Орон сууц хувьчлах товчоо холбогдох хууль журмын хүрээнд ажиллана. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| 33 | 54 | **"Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай**<br>2018-03-27, № 81<br>1. "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй | **ТӨБЗГ – БТУХ**<br>Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 81 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөл тус бүрээр гүйцэтгэгч компаниудтай санхүүжилтийн тооцоо нийлж, баталгаажуулсан.<br>"Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй 1562 айлын орон сууцны дуусаагүй барилгын гүйцэтгэлийн санхүүжилтээр зээл, зээлийн хүүгийн зардал болон | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хавсралтад заасан орон сууцны дуусаагүй барилгыг хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрт нь тооцон Хөгжлийн банкинд шилжүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт тус тус даалгасугай. | бусад зардлыг тооцон нийт 43,776,025,838.73 (дөчин гурван тэрбум долоон зуун далан зургаан сая хорин таван мянга найман зуун гучин найман төгрөг далан гурван мөнгө) төгрөгийн зардлыг өртөгт тооцон дуусаагүй барилгыг шилжүүлэхээр Хөгжлийн банкинд саналаа хүргүүлсэн.<br><br>Хөгжлийн банкнаас 5 аймгийн 1562 айлын орон сууцыг гүйцэтгэгч байгууллагад санхүүжүүлсэн дүнгээр буюу 35,477,278,512 төгрөгөөр хүлээлгэн өгч акт зурсан. Гэвч энэхүү санхүүжүүлсэн дүн нь барилгын өртөг биш учир барилгын өртөгөөр хүлээлцэхээр ажиллаж байна. Нийт барилгын өртөг нь НӨАТ орсон дүнгээр 46,480,617,835.77 төгрөг (НӨАТ-гүй дүн 42,255,107,123.43 төгрөг) юм. Одоогийн байдлаар барилгыг Хөгжлийн банк актанд зурагдсан 35.4 тэрбум төгрөгөөр хүлээн авч барилгын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байна. Хөгжлийн банктай эцсийн байдлаар тооцоо нийлсэн акт үйлдсэний дараагаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл хангаад байна. | | |
| 34 | 55 | **Агаарын бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай**<br><br>2018-03-27, № 88<br><br>1. Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор Сонгинохайрхан, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нийт 23 хорооны гэр хорооллын 20602 айл өрхийг цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэхэд зориулан эрчим хүчний дамжуулах болон түгээх шугам сүлжээ барихад шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж 2018 оны 10 дугаар сарын 1-ний дотор багтаан хэрэгжүүлж дуусгахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Засгийн газрын хуралдаанаар уг асуудалтай холбогдон гарах зардлыг 2019 оны төсөвт тусгахаар шийдвэрлэсэн. Эрчим хүчний сайдын тушаалаар 2018 онд “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК уг шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллахаар болсон.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 26 дугаар тогтоолоор “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд хийгдэх гэр хорооллын 20602 айл өрхийг цахилгаанаар халаах техникийн боломж бүрдүүлэх төсөл”-ийн ажлыг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг арилжааны банкнаас зээл авах замаар шийдвэрлэх зөвшөөрлийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн ТУЗ-д, ТӨБЗГ-ын 2018 оны 27 дугаар тогтоолоор “Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд хийгдэх 110/10 кВ-ын “Хүчит шонхор” дэд станц барих, цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулах чадварыг нэмэгдүүлэх төсөл”-ийн ажлыг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг арилжааны банкнаас зээл авах замаар шийдвэрлэх зөвшөөрлийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн ТУЗ-д тус тус олгосон.<br><br>Компаниуд зээлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу арилжааны банкнаас авч, төслийн ажлыг гүйцэтгэж байна. Тогтоолын хэрэгжилтийг хангахад шаардагдсан хөрөнгийн асуудлыг 2019 оны | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төсөвт тусган шийдвэрлэсэн. | | |
| 35 | 56 | **Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**<br><br>2018-04-25, № 111<br><br>5. Жендэрийн үндэсний хорооны ажлын албыг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллуулах болж байгаатай холбогдуулан байр, эд хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар ажлын хэсэгт орж ажиллаж байгаа. Эд хөрөнгийн асуудлыг шийдвэрлэхээр холбогдох баримт материал, тооцоог хийсэн. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 36 | 57 | **Барилга байгууламж балансаас балансад шилжүүлэх тухай**<br><br>2018-05-23, № 137<br><br>2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 857,365,418.0 төгрөгийн балансын үнэ, 15,719,232.00 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий “Хэрэглэгчдэд үйлчлэх төв”-ийн барилгыг “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-т балансаас балансад шилжүүлэх ажлын хэсэг байгуулан ажиллуулж, үл хөдлөх хөрөнгийг хүлээлцсэн. Баланс тайланд тусгасан болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 37 | 58 | **Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай**<br><br>2018-05-23, № 138<br><br>2. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, | **ТӨБЗГ – МТА**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулж, сахилга хариуцлагыг чангатгах зорилгоор Төрийн холбооны газартай хамтран 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн олон нийтийн сүлжээ (facebook, twitter)-д албаны компьютерээс хандах боломжийг хязгаарлаж, холбогдох тохиргоог хийсэн.<br><br>Мөн төрийн өмчит хуулийн этгээдэд уг тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А-1/2160 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлэв. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Хэвшиж тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй. | | | |
| 38 | 59 | **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>2018-06-20, № 188<br>5. Зарим байгууллагыг татан буулгаж, шинээр байгуулсантай холбогдуулан хууль тогтоомжийн дагуу комисс томилж, татан буугдсан байгууллагуудын эд хөрөнгөд тооллого хийж, хаалтын тайлан баланс гаргаж, үндсэн болон бусад эд хөрөнгийг шинээр байгуулагдах хуулийн этгээдэд шилжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн А-130 дугаар тушаалаар байгуулагдсан “Биокомбинат” ТӨҮГ, “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” ТӨҮГ, “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төв” ТӨҮГ-ыг тус тус татан буулгах ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл томилогдон ажиллав. | “Бүрэн хэрэгжсэн”-100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 39 | 60 | **Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай**<br>2018-06-27, № 202<br>2. “Улаангомын дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит компанийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 420 дугаар тогтоолоор “Улаангомын дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийг баталсан болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 40 | 61 | **Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2018-08-01, № 232<br>2. “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай | **ТӨБЗГ – БТУХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” 232 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК-д “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай хамтын ажиллагааны нөхцөлийг тохирох хэлэлцээрт төрийн өмч талаас | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | баримтлах бодлого, байр суурийн талаарх зөвлөмж, чиглэлийг ТӨБЗГ-ын 2018 оны А-1/3811, 2018 оны А-2/4517 дугаар албан бичгээр өгсөн. Тус зөвлөмж, чиглэлийн дагуу “Монголын төмөр зам” ТӨХК нь “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээний гол нөхцөлүүд, гэрээний төслийг 2018 оны 10 дугаар сард боловсруулан санал авахаар “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-д албан бичиг хүргүүлсэн. Төмөр замын царигийн асуудал Улсын Их Хурлаас эцэслэн шийдвэрлэгдсэний дараа “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-иас гэрээг байгуулах тухай санал ирүүлсэн. | | |
| 41 | 62 | **Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай**<br>2018-08-08, № 242<br>3. “Монголын төмөр зам” ТӨХК-иас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр “Тавантолгой төмөр зам” ХХК-д шилжүүлж, “Монголын төмөр зам” ТӨХК-д хувьцаа эзэмшүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Монголын төмөр зам” ТӨХК-иас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгөд “Улаанбаатар аудит корпораци” ХХК-иар аудит хийлгэж дүгнэлт гаргуулан, “Тавантолгой төмөр зам” ХХК-д хөрөнгийг шилжүүлсэн. Одоогийн байдлаар “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцааг “Монголын төмөр зам” ТӨХК 100 хувь эзэмшиж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 42 | 63 | **“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2018-08-08, № 245<br>3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны стратеги, дүрэм болон бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн боловсруулж, зохих журмын дагуу баталж мөрдүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Г.Нандинжаргал)-д тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор томилогдсон төрийн өмчийн төлөөлөгчид батлагдсан удирдамжийн дагуу компанийн төрийн мэдлийн 30 хувийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын байр суурийг илэрхийлэн дүрмийг батлахад саналын хуудсаар санал өгч оролцсон болно. Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлагдсан.<br>Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх компанийн бүтэц, зохион байгуулалтын талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд санал хүргүүлсэн болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 64 | **“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2018-08-08, № 245<br>6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээдийн бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Энэ тогтоол гарсантай холбогдуулан компанийн дүрмийн шинэчилсэн найруулгад 2.6-д “Компанийн төрийн мэдлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нь Монгол Улсын Засгийн газрын тогтоосноор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар байна” гэсэн өөрчлөлт оруулсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 43 | 65 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай: 1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ ажил хангалтгүй биелүүлсэн, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй 2 албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулсан.<br>ТӨБЗГ-ын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А-2/3196 дугаар албан бичгээр харьяа төрийн өмчит 72 хуулийн этгээдэд “Албан даалгавар” хүргүүлж, байгууллагын соёлыг хөгжүүлэх, төлөвшүүлэх, төрийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, компанийн гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтны ёс зүй, харилцааны талаар иргэдээс ирүүлж буй гомдол, санал, зөрчлийг арилгах, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авав. Мөн ТӨБЗГ-ын 2018 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А-2/3440 дүгээр албан бичгээр Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл өгөв.<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, захирлын контрактыг дүгнэж, 59 захирлын контрактыг 1 жилээр, 5 захирлын контрактыг 6 сараар шинэчлэн байгуулах шийдвэр гаргасан. 2018 оны сүүлийн хагас жилд ажлын үр дүнг харгалзан 2018 | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | оны контрактыг 6 сараар байгуулсан захирлуудын гэрээг дахин 6 сараар сунгав. Эрхэлсэн ажилдаа алдаа дутагдал гаргаж, түүний улмаас улсын хэмжээний салбарын үйл ажиллагаа доголдох нөхцөл байдал үүсгэсэн, контрактаар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэмт хэрэгт холбогдсон, авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн нь холбогдох хуулийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон зэрэг үндэслэл, шалтгаанаар төрийн өмчит 10 компанийн гүйцэтгэх удирдлагад хариуцлага тооцуулах талаар ТӨБЗГ-аас тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж, чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулав. Энэ хүрээнд 7 компанийн гүйцэтгэх захирлыг чөлөөлж, шинээр томилсон, 3 компанийн гүйцэтгэх захиралд цалинг 3 сар хүртэлх хугацаагаар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байна. Энэ талаарх мэдээллийг тухай бүр сарын ажлын тайланд тусган ЗГХЭГ-т мэдээлсэн. | | |
| | 66 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.2. иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>ТӨБЗГ-т 2018 онд нийт 240 өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авснаас 224, хяналтад 5, хугацаа хэтэрсэн, шийдвэрлэгдээгүй 11 (ЗХЗХ-1, БТУХ-9, ТӨБХХ-1) өргөдөл байна. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж хэвшсэн. Тайлант хугацаанд, 2017 оны жилийн эцэс, 2018 оны I, II, III улирлын шийдвэрлэлтийн тайланг газрын wwww.pcsp.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн ТӨБЗГ-ын 2018 оны өргөдөл, годлын мэдээллийг III улирлын байдлаар гарган ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>ЗГХЭГ-т хүргүүлсэн мэдээлэлд дараах мэдээллийг тусгасан: 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нийт 179 өргөдөл, гомдол газрын албан хаагчид болон иргэд, байгууллагаас бичгээр ирүүлснийг хүлээн авч Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Эдгээр өргөдөл, гомдлын 166 буюу 91 хувийг шийдвэрлэж, 12 буюу 9 хувийг хяналтад авч, 1 буюу 0 хувийг шүүхийн маргаан үргэлжилж байгаа шалтгаанаар шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн байсан. | “Бүрэн хэрэгжсэн” 100% | Хугацаа дууссан, өргөдөл, гомдлын шийдвэр-лэлтийн тайланг гаргаж, олон нийтэд мэдээлж хэвшсэн тул хяналтаас хасах саналтай. |
| | 67 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.3. төрийн албан хаагчдын ажлын | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга), Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын стратеги төлөвлөгөөг | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах; | шинэчлэн боловсруулах, ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулах замаар албан хаагчдын ажлын байрны чиг үүргийг тодорхой болгох, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, давхардал хийдлийг арилгах ажлыг төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу ажлын байрны чиг үүргийн судалгаа шинжилгээ хийсэн. Үүний үр дүнд ажлын байрны хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор 2 албан тушаалтны ажлын байрыг сэлгэн ажиллуулсан.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын А/262 дугаар тушаалаар баталсан. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн эхэлж байгаа Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-д төрийн байгууллагын стратегийн төлөвлөгөөг дээд шатны байгууллагаас боловсруулан батлах, уг төлөвлөгөөг боловсруулах аргачлал зааврыг Засгийн газраас батлах тухай заасантай холбогдуулан стратегийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг хугацаагүйгээр хойшлуулав. | | |
| | 68 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2018-08-22, № 258<br><br>1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх; | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br><br>ТӨБЗГ-ын сул орон тоонд хууль тогтоомжид заасан шаардлага хангасан 5 албан хаагчийг төрийн жинхэнэ албанд томилон, тангараг өргүүлж, төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцэн төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн 2 албан хаагч, 7 төрийн үйлчилгээний албан хаагчийг тус тус шинээр томилж, 8 албан хаагчийг чиг үүрэг өөрчилсөн болон хэлтэс хооронд шилжүүлж, 8 албан хаагчийг албан тушаалаас чөлөөлсөн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 69 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2018-08-22, № 258<br><br>1.5. төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд даргын албан тушаалд нэр дэвшүүлсэн албан хаагчдаас сонгон шалгаруулж, дүгнэлтийг дээд шатны байгууллагад хүргүүлэх тухай хүсэлтийг 2018 оны А-1/63, түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж буй албан хаагчийн жагсаалтыг 2018 оны А-3/3487, дэд даргын албан тушаалд төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн иргэний мэдээллийг 2018 оны А-1/4072 дугаар албан бичгээр тус тус Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хугацаа дуусан тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох; | | | |
| | 70 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2018-08-22, № 258<br><br>1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх; | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br><br>2018 онд амаржсаны амралттай 5 албан хаагч, 2 жилийн хугацааны сургалтад хамрагдсан 1 албан хаагчийн оронд нийт 6 албан хаагч түр ажиллаж байна. Бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллаагүй. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 71 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2018-08-22, № 258<br><br>1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод журам”-д өөрчлөлт оруулах саналыг албан хаагчдаас авч, төслийг боловсруулсан. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга) мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан байгууллагын дотоод журмын заалтуудад өөрчлөлт орох нөхцөл бий болсон тул уг асуудлыг түр хугацаагаар хойшлуулсан болно.<br><br>Нийт албан хаагчдын албан өрөө тасалгаанд эмх цэгцийг бий болгож, тэсэрч дэлбэрэх бодис, хүйтэйн зэвсэг хадгалахгүй байх талаар анхааруулга санамжийг өгч ажиллан, төрийн тусгай хамгаалалтын үзлэг хяналтад хамрагдаж, зохих зөвлөгөө анхааруулгыг хэрэгжүүлэн хэвшээд байна.<br><br>Ажлын байранд согтууруулах ундаа хадгалсан, хэрэглэсэн, хориглосон эд зүйлсийг хадгалсан, оруулсан тохиолдол тогтоогдоогүй. | “Хэрэгжиж шатанд” -70% | |
| | 72 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2018-08-22, № 258<br><br>1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>2018 онд ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ ажил төлөвлөсөн хугацаанд биелүүлээгүй, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй 2 албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах; | дотоод журмын дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулж, 1 албан хаагчийн асуудлыг ТӨБЗГ-ын “Ёс зүйн хороо”-оор хэлэлцэн, сануулга өгч, бусад албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн.<br><br>ТӨБЗГ-ын албан хаагчдын дунд “Хууль тогтоомж сурталчлах сарын аян”-ыг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулав. Энэхүү аяны хүрээнд төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, төрийн өмчийн бүртгэл, хяналт, төрийн өмчийн удирдлага, менежмент, төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд тус тус дагаж мөрдөж буй хууль тогтоомж, ТӨБЗГ-ын дотоод журам, эрх зүйн актыг танилцуулах, сурталчлах, судлуулах, сургалт, уралдаант, хөгжөөнт тэмцээн уралдаан зэрэг олон талт ажлуудыг зохион байгуулав.<br><br>АТГ-аас зохион байгуулсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 23 удаагийн сургалтад батлагдсан хуваарийн дагуу давхардсан тоогоор 72 албан хаагчийг хамруулав. Мөн худалдан авах ажиллагаанд авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх 1 сургагч багшийг АТГ-тай хамтран бэлтгэв. | | |
| | 73 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2018-08-22, № 258<br><br>1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг дотоод сүлжээ, цаг бүртгэлийн төхөөрөмж, хяналтын камерын системээр бүртгэдэг бөгөөд хяналтыг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах, зөрчил доголдлыг арилгахад чиглэсэн ажлыг албан хаагчдын цалинтай уялдуулах замаар зохион байгуулж байна. Сар бүр хэлтэс, албаны дарга нар цаг бүртгэлийн тайланг хянан баталгаажуулж хэвшсэн.<br><br>Гадуур ажилтай албан хаагчдын мэдээллийг өмнөх өдөр нь гаргаж Төрийн тусгай хамгаалалтын газрын Харуул хамгаалалтын албаны ажилтанд өгч, байгууллагад нэвтрэх зохион байгуулалтыг хэвшүүлж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 74 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2018-08-22, № 258<br><br>1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга) хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан тус журмын заалтуудад өөрчлөлт орох нөхцөл бий болсон тул уг асуудлыг түр хугацаагаар хойшлуулсан болно. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах; | | | |
| | 75 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>3. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>ТӨБЗГ-т Төрийн тусгай хамгаалалтын газрын Хамгаалалтын албанаас хийсэн шалгалтад 2 удаа хамрагдсан. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмээг авч ажилласаны үр дүнд тус шалгалт, хяналтаар ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй байна. | “Хэрэгжих шатанд” -70% | |
| 44 | 76 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2018-09-12, № 286<br>1. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 5986 м.кв талбай бүхий 5 барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Хөрөнгийн болон газар эзэмших эрхийн үнэлгээ хийх этгээдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2018 оны А/268 дугаар тушаалаар байгуулсан. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийлгэх тухай зарыг Зууны мэдээ сонины 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдөр, Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ сонины 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дугааруудад зарыг нийтлэн нийтэд мэдээллийг хүргэсэн. Үнэлгээний зөвлөх үйлчилгээ хийх этгээдийг сонгон шалгаруулах ажиллагааг 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр явуулж, “Итгэлт бээс” ХХК шалгарсан. Тус компанитай үнэлгээ хийх гэрээ байгуулсан бөгөөд Үнэлгээний тайланг хугацаандаа ирүүлээд байна.<br>Тээврийн цагдаагийн алба газар эзэмших эрхийн гэрчилгээ, кадастрын зургаа гаргуулахаар Нийслэлийн Засаг даргад хандсан байгаа тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах асуудлыг хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх ажил түр хүлээгдэж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 45 | 77 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай (Говь-Алтай, Алтай сум. “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-иас Зэвсэгт хүчний 304 дүгээр тусгай салбарт)**<br>2018-10-03, № 292<br>2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Говь-Алтай аймгийн Алтай сумын нутаг дэвсгэрт байрлах “Алтай Улиастайн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 33,577,500.00 (гучин гурван сая таван зуун далан долоон мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий 1 давхар дизелийн барилгыг Зэвсэгт хүчний 304 дүгээр тусгай салбарт балансаас балансад шилжүүлэх ажлыг хоёр талаас төлөөлөл оролцуулж, Ажлын хэсэг байгуулан хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулав. Баланс тайланд тусгасан болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 46 | 78 | **Үл хөдлөх хөрөнгиийн зарим хэсгийг балансаас балансад шилжүүлэх тухай (Баян-Өлгий аймаг дахь битүү захын зарим хэсэг)**<br>2018-10-03, № 293<br>2. Үл хөдлөх хөрөнгийн зарим хэсгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>УИХ-ын 2018 оны 6 дугаар сарын 28-ны 61 дүгээр тогтоолын дагуу Баян-Өлгий аймгийн битүү захын 60 хувь болох 1,831,500,000.00 төгрөгийн балансын үнэ бүхий барилгыг Баян-Өлгий аймгийн Орон нутгийн өмчид шилжүүлэн хүлээлцэх ажлыг ТӨБЗГ-ын даргын А/32 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж, эд хөрөнгийг хүлээлцсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 47 | 79 | **Хорих анги болон төрийн өмчит үйлдвэрийн газар татан буулгах тухай**<br>2018-10-10, № 304<br>3. Татан буугдсан хорих ангиудын эд хөрөнгө, төсөв, санхүү, орон тоог хууль тогтоомжид заасны дагуу шилжүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид, “Авдрант хайрхан” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Ц.Амгаланбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын | **ТӨБЗГ – БТУХ**<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар “Татан буулгах ажлын хэсэг” томилогдон хууль тогтоомжид заасны дагуу “Авдрант хайрхан” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын өр, авлагыг барагдуулан, эд хөрөнгө болон холбогдох ажиллагсдыг харьяа байгууллагуудад шилжүүлэх арга хэмжээг аваад байна. Татан буулгах ажил 90 орчим хувийн гүйцэтгэлтэй байна. Тус үйлдвэрийн газрын эд хөрөнгийг харьяа байгууллагуудад шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | газрын дарга Ц.Ням-Осор нарт тус тус даалгасугай. | | | |
| 48 | 80 | **“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай**<br>2018-10-31, № 328<br>2. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төслийг боловсруулж, 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр БХБЯ-аас санал авахаар албан шугамаар хандсан. БХБЯ-наас дүрмийн төслийн талаар санал ирүүлсэний дараа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 81 | **“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай**<br>2018-10-31, № 328<br>3. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, компанийн өр, авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Хөгжлийн банкны зээлээр барьж буй байруудыг “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт хамруулах тухай Засгийн газрын 2018 оны 81 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан 82.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий орон сууцыг Түрээсийн орон сууцын санд шилжүүлсэн. Энэхүү үнийн дүнг “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-т олгох ёстой тул БХБЯ-наас 2019 оны улсын төсөвт нийт 5.0 тэрбум төгрөгийг тусгасан. Цаашид дээрх дүнг улсын төсөвт үе шаттай суулгах замаар асуудлыг шийдвэрлэнэ. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | | **ЗГТогтоол: 42 шийдвэрийн 74 заалт** | **100% - 55 заалт; 70% - 13 заалт; ХБ – 6 заалт;**<br>**Хэрэгжилтийн хувь – 94.3%.** | | |
| **Тав. Ерөнхий сайдын захирамж** | | | | | |
| 49 | 82 | **Ажлын хэсэг байгуулах тухай**<br>2018-04-05, № 66<br>2. Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал | **ТӨБЗГ – БТУХ**<br>Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл”, Засгийн газрын 2003 оны 34 дүгээр тогтоолын хэрэгжилт, биелэлтийг Ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн болно. Ажлын хэсгийн даргаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хийх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, цаашид тус салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх саналыг холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулж 2018 оны 6 дугаар сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Г.Занданшатар)-т даалгасугай. | дарга Г.Занданшатар томилогдсон бөгөөд дарга хурлын товыг зарлан хуралдуулах хүртэл бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | | |
| 50 | 83 | **Ажлын хэсэг байгуулах тухай**<br>2018-08-14, № 142<br>2. "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын хөрөнгийн дахин үнэлгээг хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэж, хөрөнгийн тооллого болон дахин үнэлгээ хийсэн талаарх тайланг 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Энэхүү захирамжаар Монгол-Японы хамтарсан хуулийн этгээд байгуулахтай холбогдуулан санхүү, эрх зүйн зохицуулалтын талаарх тооцоо, судалгаа хийх чиг үүрэгтэй ажлын хэсэг байгуулсан.<br>Харин Засгийн газраас "Чингис хаан" Олон улсын нисэх буудлыг цаашид зориулалтын дагуу ашиглах чиглэл өгч, ""Буянт ухаа" нисэх буудал байгуулах тухай" тогтоолын төсөл боловсруулан хэлэлцүүлэх гэж байна.<br>Иймд тус буудлын хөрөнгийг шинээр зохион байгуулагдах байгууллагад балансаас балансад шилжүүлэх болсон тул энэхүү захирамжаар томилогдсон ажлын хэсэг ажиллах шаардлагагүй болсон болно. | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | Цаашид уг ажлын хэсэг ажиллах шаард-лагагүй болсон тул хяналтаас хасах саналтай. |
| | | **ЕС-ын захирамж:**<br>**2 шийдвэрийн 2 заалт** | **70% - 1 заалт; ХБ - 1 заалт; Хэрэгжилтийн хувь – 70%.** | | |
| **Зургаа. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 51 | 84 | **Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах талаар авах арга хэмжээний тухай**<br>2014-01-11, № 02<br>5. Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цахим дэлгүүр ажиллуулах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн программ хангамж, техникийн шийдэл, нөхцлийг ашиглан Цахим худалдан авах ажиллагааны системийг мэдээлэл солилцох төвлөрсөн сүлжээгээр дамжуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх | **ТӨБЗГ – МТА**<br>Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем www.tender.gov.mn -ийг 2017 оноос бүх худалдан авах ажиллагааны захиалагч байгууллагууд ашиглаж байгаа бөгөөд "Мэдээлэл солилцоо" дэд системийн шийдлийг боловсруулсан. Энэхүү дэд системээр дараах төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцооны шуурхай, бодит байдлыг хангах асуудлыг шийдвэрлэж, тендер шалгаруулалтын ажилд ашиглаж байна. Тухайлбал, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас Үндэсний Дата төвөөр дамжуулан хуулийн этгээдийн талаарх мэдээллийг солилцох тухай 2016 онд байгуулсан №14/30 тоот гэрээний хүрээнд ажиллаж байна.<br>Сангийн яамны "Санхүүгийн тайлангийн е-баланс" системээс хуулийн этгээдийн борлуулалтын орлого, түргэн хөрвөх чадвар, санхүүгийн тайлан зэргийн талаарх мэдээллүүдийг, Татварын ерөнхий газрын татвар төлөгчийн мэдээллийн сангаас татварын үлдэгдэл болон үйл | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийн системтэй холбох ажлыг зохион байгуулахыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаа, Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Пүрэвдорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Ядамдорж, НДЕГ-ын дарга Ц.Уртнасан нарт тус тус даалгав. | ажиллагааны борлуулалтын орлого, автомашины лавлагааг авах зэрэг мэдээллийг цахим хэлбэрээр солилцож байна.<br><br>Цахим худалдан авах ажиллагааны “Мэдээлэл солилцоо” дэд системийг ШШГЕГ-тай холбож шүүхийн лавлагаа тодорхойлолтыг веб сервисээр авах боломж, нөхцлийн талаар санал солилцох уулзалт хийсэн.<br><br>Түүнчлэн төрийн байгууллагууд дундаас анх удаа Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлж, үндэсний тоон гарын үсгийн дэд системд холбогдон тендерт оролцогч аж ахуйн нэгжүүд уг гарын үсгийг ашиглан тендерт оролцох материалаа цахим хэлбэрээр баталгаажуулан ирүүлэх боломжийг бүрдүүлсэн.<br><br>Төрийн худалдан авах ажиллагаанд Үндэсний дата төвд байрлах төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг ашиглах талаар “Үндэсний дата төв” УТҮГ-тай 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр 18/08 дугаар гэрээг байгуулан ажиллаж байна. Автотээврийн үндэсний төвийн вэб сервисийн холболтын ажлыг эхлүүлсэн. | | |
| 52 | 85 | **Худалдан авах ажиллагааны тухай**<br><br>2016-09-28, № 48<br><br>XYII.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов. | **ТӨБЗГ – ХААХ**<br><br>ТӨБЗГ-аас 2018 онд зохион байгуулах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны жагсаалтад бараа худалдан авах 10 (эмнэлэгийн тоног төхөөрөмж) төсөл байгаа бөгөөд захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолт, барааны жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүний шаардлага тусгагдаагүй болно.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 онд зарласан нийт 133 тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор үндэсний үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг барилга угсралтын ажилд ашиглах тохиолдолд бараа материал болон ажиллах хүчний хувьд дотоодын давуу эрх тооцохоор тендерийн баримт бичигт тусгасан. 2018 онд гэрээ байгуулсан 121 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад хүсэлт ирүүлсэн 31 компанид дотоодын давуу эрх тооцож олгосон байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 86 | **Худалдан авах ажиллагааны тухай**<br><br>2016-09-28, № 48 | **ТӨБЗГ – ХААХ**<br><br>Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2018 онд улсын төсвийн | “Бүрэн хэрэгжсэн” – | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | XYII.2.6. Төсвийн байгууллагын байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.11-д заасны дагуу ерөнхий гэрээ байгуулан, мөн хуулийн $10^{1}$ дүгээр зүйл, 53.5.7-д заасны дагуу тус тус зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) болон бүх шатны төсвийн шууд захирагч нарт үүрэг болгов. | хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-д "Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах" ажил тусгагдсан. Энэхүү ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://tender.gov.mn -ийн дэд систем болох "Цахим дэлгүүр"-ээр дамжуулан Монгол улсад анх удаа зохион байгуулж байна. Зарим ерөнхий нэршлийн 17 нэр төрлийн эмийг ханган нийлүүлэх 10 аж ахуйн нэгжтэй давхардсан тоогоор 40 ерөнхий гэрээ байгуулсан. 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд нийт 361 удаагийн захиалгаар 814144 ширхэг эм худалдан борлуулагдсан бөгөөд улсын төсөвт 325.4 сая төгрөгийн хэмнэлт гарсан тооцоотой байна. | 100 % | |
| 53 | 87 | **Үрийн төрөлжсөн аж ахуй байгуулах тухай**<br><br>2016-11-16, № 55<br><br>XXYI.6. Дарханы ургамал, газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэн болон үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжтэй хамтран үрийн төрөлжсөн аж ахуй байгуулах асуудлыг судалж танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт; | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Дарханы ургамал, газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэн болон үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжтэй хамтран үрийн төрөлжсөн аж ахуй байгуулах асуудлаар ХХААХҮЯ, БСШУСЯ бодлогын түвшинд судалж, санал боловсруулан шийдвэрлүүлсний дараа төрийн өмчийн асуудлыг зохицуулах боломжтой. Одоогоор тодорхой санал, шийдвэрийн төсөл ирүүлээгүй байна.<br><br>Салбарын яамны шийдвэрлэх асуудал тул ТӨБЗГ-аас хамаарахгүй. | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | ТӨБЗГ-аас шууд хамаарч шийдвэрлэх асуудал биш хяналтаас хасах саналтай. |
| 54 | 88 | **Төрийн өмчийн хуулийн этгээдүүдийг татан буулгах асуудлын тухай**<br><br>2017-01-25, № 04<br><br>IY. "Монгол тариалан корпораци", "Монгол мах корпораци", "Аж үйлдвэрийн цогцолбор" төрийн өмчийн хуулийн этгээдүүдийг татан буулгах асуудлыг хэлэлцээд газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, махны нөөц бүрдүүлэх ажлыг "Монгол тариалан корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газар, "Монгол мах | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг нэмэгдүүлэх, удирдлага, менежмент, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаа нь зогссон, алдагдалтай ажиллаж байсан "Монгол тариалан корпораци" ТӨҮГ, "Монгол мах корпораци" ТӨҮГ, "Монгол тамга" ТӨҮГ, "Аж үйлдвэрийн цогцолбор" ТӨХК, "Авто замын тоног төхөөрөмжийн түрээс" ТӨХК-ийг татан буулгах асуудлыг судалж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасны дагуу эдгээр төрийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах асуудлаар холбогдох яамны саналыг тусгасан үндэслэл бүхий санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авсан. Засгийн газрын 2018 оны 09 дүгээр тогтоолоор эдгээр төрийн өмчит хуулийн этгээдийг татан буулгасан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар холбогдох | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | Бүрэн хэрэгжсэн, дараагийн шийдвэр гарсан тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газруудаар гүйцэтгүүлэх боломжийг судлан үзэж, татан буулгах гэж байгаа зарим байгууллагын өр, төлбөрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж, Засгийн газрын дараагийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт даалгав. | байгууллагын төлөөллийг оролцуулсан татан буулгах 4 комиссыг байгуулан ажиллуулж байна. Татан буулгах комисс нь хуулийн этгээдийн өр, авлагыг барагдуулах, тооцоо нийлэх, зөрчил хохирлыг шийдвэрлүүлэх чиглэлээр ажиллаж байна. Ажил эцэслэн дуусч, дүн гараагүй байна. | | |
| 55 | 89 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2017-08-17, № 36<br>III.2. Яам, Засгийн газрын агентлаг, төсөвт байгууллагын харьяанд ажилладаг амралтын газрын талаар болон төсвөөс санхүүжүүлдэг амралтын газрыг худалдах, хувьчлах саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Яам, Засгийн газрын агентлаг, төсөвт байгууллагын харьянд ажилладаг амралтын газар болон төсвөөс санхүүжүүлдэг амралтын газар, түүний хөрөнгийн бүртгэл, санхүүжилтийн талаар судалгаа хийж, нэгдсэн мэдээлэл гаргасан. Тус мэдээлэлд дүн шинжилгээ хийн холбогдох байгууллагуудын саналыг авахаар ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 90 | **Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах, үйл ажиллагааг эхлүүлэхэд тулгамдаж байгаа асуудлын тухай**<br>2017-08-17, № 36<br>7.4. Агаарын хөлгийн шатахуун хангамжийн гидрант системийн үйл ажиллагааны схемийг тодорхойлж, шатахуун хангамжийн үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг судалж шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Агаарын хөлгийн шатахуун хангамжийн гидрант системийн үйл ажиллагааны схемийг тодорхойлж, шатахуун хангамжийн үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг судалж шийдвэрлэх асуудлыг Үндэсний хөгжлийн газрын зүгээс Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 223 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулж, Олон улсын шинэ нисэх буудлын шатахуун хангамжийн менежментийг хэрэгжүүлэх ажлыг “Хөрөнгө оруулах-ашиглах-шилжүүлэх концесс”-ын төрлөөр шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Шийдвэр-лэгдсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 56 | 91 | **Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай**<br>2017-09-13, № 39<br>XXII.2.1. 2017 онд худалдан авах | **ТӨБЗГ – ХААХ**<br>2018 онд ТӨБЗГ-аас зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн худалдан авах боломж бүхий барааны | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааг зохион байгуулахдаа хууль тогтоомжийн дагуу дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчийг давуу эрхээр шалгаруулж байгааг сайшаан, цаашид дотоодын аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов | төсөл, арга хэмжээ тусгагдаагүй. Мөн энэ төрлийн барааны худалдан авах ажиллагаа эрх шилжиж ирээгүй байна.<br>Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор тус газраас зарласан нийт тендер шалгаруулалтын дүнд гүйцэтгэх ажилд дотоодод үйлдвэрлэсэн чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн ашиглах бол давуу эрх олгохоор тендерийн баримт бичигт тусгайлан зааж байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар гэрээ байгуулсан 121 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад хүсэлт ирүүлсэн 31 компанид дотоодын давуу эрх олгосон байна. | | |
| | 92 | **Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай**<br>2017-09-13, № 39<br>XXII.2.2. Төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | **ТӨБЗГ – ХААХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу хагас жил, жилийн эцсийн байдлаар ТӨБЗГ-т зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тайланг Сангийн яаманд хүргүүлж байна.<br>Харин нийслэл, 21 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны явцын мэдээг сар, улирлаар хүлээн авч, дүн шинжилгээ хийн арга зүйн зөвлөгөө, чиглэл өгч байна. Орон нутгаас ирүүлсэн санал, хүсэлтийг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсэн байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 57 | 93 | **”Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Монголросцветмет” ХХК-ийн энгийн хувьцааны 49 хувийг төрийн өмчид шилжүүлэн авсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br>2018-01-04, № 2<br>2. ”Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “Монголросцветмет” ХХК-ийн энгийн хувьцааны 49 хувийг төрийн өмчид шилжүүлэн авсантай холбогдуулан эдгээр төрийн өмчит хуулийн этгээдийн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу баталж мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 7 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн, 6 дугаар тогтоолоор “Монголросцветмет” ХХК-ийн дүрмийг тус тус баталж, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар (хуучин нэрээр) бүртгэсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 58 | 94 | **”Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцааны тухай**<br><br>2018-01-10, № 3<br><br>III.2. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6, 7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, ”Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрүүдэд заасан эдгээр аж ахуйн нэгжийн 49 хувийн энгийн хувьцааг төр давуу эрхээр худалдан авах тухай заалтыг зөрчсөн эсэх, компанийн 49 хувийн энгийн хувьцааны төлбөрийг төлсөн банк, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний үйл ажиллагаа хууль тогтоомжийг зөрчсөн эсэх асуудлыг хууль хяналтын байгууллагад хандан шалгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөв. | **ТӨБЗГ – БТУХ, ЗХЗХ**<br><br>Тэмдэглэлийн заалтад дурдсан асуудлаар хууль хяналтын байгууллагад хандан шалгуулах эрх хэмжээ хуулиар олгогдоогүй тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамаарахгүй байна.<br><br>“Монголиан коппер корпорейшн” ХХК-ийн нэхэмжлэлтэй иргэний болон захиргааны хэрэг шүүхээр хянагдаж байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь уг хэргийн талаарх мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Хууль зүй, дотоод хэргийн яаманд удаа дараа албан бичгээр хүргүүлсэн болно (2017.10.23-ны өдрийн А-1/2884, 2017.12.12-ны өдрийн А-1/3529, 2017.12.12-ны өдрийн А-1/3536, 2018.05.25-ны өдрийн А-1/1756 дугаар албан бичиг)<br><br>Энэхүү маргааны талаар чиглэл хүссэн албан бичгийг боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Хууль зүй дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А-1/4801-4803 тоот албан бичгээр хүргүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжилт нь ТӨБЗГ-аас хамаарах-гүй байна.<br><br>Иймээс хяналтаас хасуулах саналтай. |
| 59 | 95 | **“Барилгын хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай**<br><br>2018-01-31, № 7<br><br>YIII.2. Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг болон “Барилгын хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>“Барилгын хөгжлийн төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, үйл ажиллагаанд давхардал, хийдэл байгаа эсэхийг нягтлан шалгахад давхардал, хийдэл илрээгүй. Гарсан дүн, дүгнэлтэд үндэслэн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Хэлэлцсэн асуудалтай холбоотойгоор Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 51 дүгээр тогтоол батлагдсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн өмчийн | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн, дараагийн шийдвэр буюу 2018 оны 51 дүгээр тогтоол гарч, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | газрын хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, үйл ажиллагаанд давхардал, хийдэл байгаа эсэхийг нягтлан шалгаж, хууль хяналт болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө байгууллагаас гаргасан дүгнэлтийг судлан үзэж шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгав. | бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 85 дугаар тогтоолоор “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцэд Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа, төлөвлөлтийн хэлтэс (9), Хот суурин, дэд бүтцийн судалгаа, төлөвлөлтийн хэлтэс (6) гэсэн 2 хэлтэс нэмж, нийт 145 орон тоотой ажиллуулахаар дүрэм, зохион байгуулалтын бүтцийн схем, захиргааны албан тушаалыг шинэчлэн баталсан. | | бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| | 96 | **Хэнтий аймгийн Бэрхийн уурхайд ажиллаж байсан иргэдийн нөхөн төлбөртэй холбоотой асуудлын тухай**<br>2018-01-31, № 7<br>XY.5. Хэнтий аймгийн Бэрхийн уурхайд ажиллаж байсан иргэдийн нөхөн төлбөртэй холбоотой асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох сайд, дарга нарт даалгав: 1. “Бэрх-Уул” төрийн өмчит хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байсан үед буюу 1999-2004 оны хооронд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосон иргэдийн нөхөн төлбөрийн асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон бусад төрийн байгууллагатай хамтран дахин нягтлан үзэж саналаа Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т; | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Засгийн газрын тэмдэглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох төрийн захиргааны байгууллагаас албан хаагчдыг ажиллуулахаар 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдөр Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тус тус албан бичиг хүргүүлсэн. Сангийн яам, Хууль зүй, дотоодын хэргийн яамнаас төлөөлөл ажиллахгүй тухай мэдэгдсэн тул 2018 оны 7 дугаар сарын 04-ний өдөр дахин албан бичиг хүргүүлж, заавал салбар яамдын бүрэлдэхүүнийг оролцуулах шаардлагатайг мэдэгдсэн. Сангийн яамнаас 2 удаа татгалзсан хариу ирүүлсэн.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Бэрх-Уул” ТӨХК-д ажиллаж байсан ажиллагсдын төлөөлөл Б.Алтангэрэлийн өргөдлийг хүлээн авч, 3 удаагийн уулзалт хийн, ажлын хэсэг байгуулах үйл явцын тухай мэдээлэл өгсөн.<br>Ажиллагсдын төлөөлөл Б.Алтангэрэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Г.Баясгалантай 2019 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр уг асуудлаар уулзалт зохион байгуулахаар товлосон тул хоёр талын уулзалтаас гарах шийдвэрийг харгалзан ажиллагсдын нөхөн төлбөрийн асуудлаар цаашид авах арга хэмжээг зохион байгуулна. | “Хэрэгжилт хангалтгүй” – 30% | |
| 60 | 97 | **Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх улирлын** | **ТӨБЗГ – ХААХ**<br>ТӨБЗГ-аас худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах зорилгоор төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | 2018 онд хэрэгжүү-лэх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тухай**<br>2018-03-13, № 13<br>ҮIII.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх улирлын чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар гарган Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. 1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов: -улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлэх; -эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах; -хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, тайлан мэдээг Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэх. | техник, эдийн засгийн үндэслэлийг яаралтай ирүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчдад нийт 7 удаа албан бичиг хүргүүлсэн.<br>ТӨБЗГ-т худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардагдах төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг холбогдох материалыг төсвийн ерөнхийлөн захирагчаас хуулийн хугацаанд ирүүлээгүйн улмаас тендер шалгаруулалт мөн хугацаагаар хойшилсон. 2018 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна. 2018 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ТӨБЗГ-т 35 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт дуусч, гүйцэтгэгч, захиалагчийн хооронд гэрээ байгуулсан. Энэ нь нийт зохион байгуулах ажлын 25 хувь болж байв. БСШУСЯ 3, ЭМЯ 7, БХБЯ 2, ЗТХЯ 1, нийт 13 төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар ирүүлээгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулж эхлээгүй байсан. 2018 оны жилийн эцсийн байдлаар 133 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас нийт 121 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг дуусч, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. Худалдан авах ажиллагааны явц 91.0 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, мэдээ нэгтгэн 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А-1/111 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 2018 оны худалдан авах ажиллагааны тайланг хуульд заасан хугацааны дагуу Сангийн яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг сар, улирал, хагас жилийн байдлаар хүргүүлэн мэдээлсэн. | | хугацаа-тай, хэрэгжүү-лэх хугацаа дууссан тул хяналтаас хасах саналтай. |
| 61 | 98 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2017 оны санхүүгийн тайлан тэнцлийн дүнгийн тухай**<br>2018-03-27, № 15<br>XXIX.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн | **ТӨБЗГ – БТУХ**<br>1.Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын контрактын гэрээг холбогдох журмын дагуу дүгнэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн “Урамшуулал олгох тухай” 323 дугаар тогтоолоор контрактын биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн нийт 46 хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх захиралд олгох урамшууллын хэмжээг компанийн цэвэр ашиг, ногдол | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2017 оны санхүүгийн тайлан тэнцлийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгав: 1. санхүү, эдийн засгийн зорилтоо хангаж, үр ашгийг сайжруулсан хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын контрактын гэрээг холбогдох журмын дагуу дүгнэж урамшуулахдаа компанийн цэвэр ашиг, ногдол ашиг, өглөг, авлагын хэмжээтэй нягт уялдуулан авч үзэх; 2. дэвшүүлсэн зорилтоо биелүүлээгүй, ашиггүй ажилласан, өглөг, авлагаа нэмэгдүүлсэн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагад тодорхой хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавих; 3. компанийн засаглалыг сайжруулах, үргүй зардлыг багасгах талаар санал боловсруулж, төрийн өмчит зарим хуулийн этгээдийг өөрчлөн зохион байгуулах төслийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг авсны үндсэн дээр боловсруулан Засгийн газарт танилцуулж байх. | ашиг, өглөг, авлагын хэмжээтэй уялдуулан тогтоож, урамшууллыг олгосон.<br><br>2.Дээд шатны байгууллага болон ажиллагсдаас өргөдөл ирүүлсэн, ажлын гүйцэтгэл хангалттай сайн бус үнэлэгдсэн 5 захирлын контрактыг 6 сараар байгуулах шийдвэр гаргасан. 2018 оны эхний хагас жилийн ажлын үр дүнг харгалзан контрактыг дахин 6 сараар сунгаж байгуулсан.<br><br>3.Төсвийн ачааллыг багасгах, компанийн засаглалыг сайжруулах, үргүй зардлыг багасгах зорилгоор алдагдалтай ажиллаж байсан болон үйл ажиллагаа нь зогссон “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК, “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК, “Монгол тамга” ТӨҮГ, Монгол тариалан ТӨҮГ, “Монгол мах” ТӨҮГ-ыг татан буулгах санал боловсруулан Засгийн газарт хүргүүлсэн. Засгийн газрын 2018 оны 09 дүгээр тогтоолоор нэр дурдсан хуулийн этгээдийг татан буулгасан. Мөн Засгийн газрын 2018 оны 188 дугаар тогтоолоор “Биокомбинат” ААТУҮГ, “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” ААТУҮГ, “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” ААТУҮГ-ыг татан буулгасан бол Засгийн газрын 2018 оны 328 дугаар тогтоолын дагуу “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-ыг төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулав. | | |
| | 62 | 99 | **Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагад интернетийн зохистой хэрэглээг бий болгох арга хэмжээний тухай**<br><br>2018-04-04, № 16<br><br>ХҮ.2. Ажлын байранд, ажлын цагаар интернэт ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг | **ТӨБЗГ – Бүх хэлтэс**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулж, сахилга хариуцлагыг чангатгах зорилгоор Төрийн холбооны газартай хамтран олон нийтийн сүлжээ (facebook, twitter)-д албаны компьютерээс хандах боломжгүй болгож холбогдох тохиргоог 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн хийсэн.<br><br>Мөн төрийн өмчит хуулийн этгээдэд уг тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А-1/2160 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлэв. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сайжруулах арга хэмжээ авч “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн захирлуудад үүрэг болгосугай. | | | |
| | 100 | **Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, түүний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнгийн тухай**<br>2018-04-04, № 16<br>XYI.9. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, түүний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнгийн талаар Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 1. 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, тендер шалгаруулалтын явц 2018 оны I улирлын байдлаар “хангалтгүй” буюу 27.7 хувьтай байх тул тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, Засгийн газрын 2017 оны 337, 2018 оны 34 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажиллах; 1.1. худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийтлэх, тендерийн урилга, үр дүнг тухай бүр системд оруулж нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллах; 1.2.өөрийн харьяаны 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд | **ТӨБЗГ – ХААХ**<br>1.1.ТӨБЗГ-т зохион байгуулагдаж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр (www.tender.gov.mn) зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, олон нийтэд мэдээлж байна.<br>1.2.Төрийн өмчит 85 компани, үйлдвэрийн газарт “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах тухай журам”-ын дагуу 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан болон 2018 оны төлөвлөгөөг ирүүлэх талаар ТӨБЗГ-ын А/3672 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Компаниудын ирүүлсэн тайлан, төлөвлөгөөг нэгтгэх ажлыг гүйцэтгэсэн (МТА-цахим).<br>1.3.ТӨБЗГ-т зохион байгулсан 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А-1/111 дугаар албан бичгээр, 2018 оны эхний хагас жилийн тайланг 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 2/2128 дугаар албан бичгээр Сангийн яаманд шинэчлэгдсэн журмын дагуу тус тус хүргүүлсэн.<br>1.4.ТӨБЗГ-ын 2018 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад 10 (эмнэлэгийн тоног төхөөрөмж) бараа худалдан авах төсөл тусгагдсан бөгөөд захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолт, барааны жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн тусгагдаагүй болно. Харин ТӨБЗГ нь дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн ашиглах эсэх, ашиглах бол бараа бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртгийн талаар мэдэгдэл, хүсэлт ирүүлж, дотоодын давуу эрх тооцуулах боломжтой талаар нийт тендерийн баримт бичигт тусгайлан зааж өгч байна. 2018 онд гэрээ байгуулсан 121 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад хүсэлт ирүүлсэн 31 компанид дотоодын давуу эрх олгосон байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Сангийн яаманд хүргүүлэх; 1.3.худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд багтаан зохион байгуулж, тайланг бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр тус бүрээр гаргаж тайлагнах; 1.4. барааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10[1]-д заасны дагуу дотоодын үйлдвэрээс худалдан авах, Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах. | | | |
| | 101 | **Цахим худалдлан авах ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай**<br>2018-04-04, № 16<br>ХYI.9.2. Цахим худалдан авах ажиллагааг сайжруулах, статистик тоон мэдээллийн давхардалгүй, үнэн зөв байдлыг хангах, ерөнхий гэрээ байгуулах ажлыг эхлүүлэхтэй холбоотойгоор цахим дэлгүүрийн хэвийн ажиллагааг хангаж, холбогдох гарын авлагыг боловсруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т үүрэг болгов. | **ТӨБЗГ – МТА**<br>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.pcsp.gov.mn -ийн ашиглалтыг нэмэгдүүлэх, цахим худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах зорилгоор цахим худалдан авах ажиллагааны системийн сургалтыг худалдан авах ажиллагааны захиалагч байгууллага, тендерт оролцогч аж ахуйн нэгжийн төлөөлөлд нийт 89 удаа зохион байгуулж, 2814 албан хаагч, иргэнийг оролцуулав.<br>Улсын хэмжээнд худалдан авах ажиллагааны тогтолцоог цахим хэлбэрт шилжүүлэх, шилэн тендерийн бодлого баримтлах, худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод болгох зорилгоор худалдан авах ажиллагааны цахим системийг боловсронгуй болгон хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Ингэснээр улсын хэмжээний худалдан авах ажиллагааны статистик тоон мэдээ мэдээлэл тодорхой болж, дүгнэлт, дүн шинжилгээ хийх боломжтой болсон. 2018 оны жилийн эцсийн байдлаар, тус системд 1433 захиалагч байгууллагын 21417 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нийтлэгдсэн, 10817 тендер шалгаруулалтын урилга зарлагдсан (9574 нь цахим тендерийн урилга), 10202 тендерийн үр дүн нийтлэгдсэн байна. Зарласан тендерийн урилга өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6514-өөр буюу 151 хувиар нэмэгдэж, нийт тендер шалгаруулалтад эзлэх цахим тендер шалгаруулалтын хувь 88.5 хувь байгаа нь өмнөх оноос 1.9 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Цахим системд тендер шалгаруулалтын 1511 гэрээ нийтлэгдсэн нь өмнөх оныхоос 1409 өөр нэмэгдсэн байна. Цахим сиемтемд бүртгэлтэй тендерт оролцогчдын тоо 10102 болж 2017 онтой харьцуулахад 94%-иар ахисан.<br>Бараа, ажил, үйлчилгээний ангилалын системд нийт 23857 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байна. Дотоодын үйлдвэрлэгчдийн бараа, | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | үйлчилгээний каталоги үүсгэх, мэдээллийг “Цахим дэлгүүр”-т нэгтгэхээр төлөвлөн ажиллаж байна.<br><br>2018 онд улсын хэмжээнд анх удаа “Ерөнхий гэрээ”-ий тендер шалгаруулалтыг зохион байгуулж, ерөнхий нэршлийн 17 нэр төрлийн эмийг нийлүүлэх эм ханган нийлүүлэгч 10 компанитай нийт 40 гэрээ байгуулсан. Тэдгээрийн нийлүүлэх эмийн бүтээгдхүүнийг “Цахим дэлгүүр”-ээр худалдан борлуулж, 325.4 сая төгрөгийн хэмнэлт гаргав.<br><br>Ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах, “Цахим дэлгүүр”-ийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх сургалтыг ТӨБЗГ-аас СЯ, ЭМЯ-тай хамтран 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж, эрүүл мэндийн холбогдох байгууллагын нийт 58 ажилтныг хамруулав. | | |
| 63 | 102 | **“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хуулийн этгээд байгуулах тухай**<br><br>2018-05-02, № 20<br><br>XX.4. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох хувийг эзэмших төрийн өмчит компани байгуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 150 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох 49 хувийг эзэмших “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийг байгуулж, уг компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Зам, тээврийн хөгжлийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг томилсон. Хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн дүрмийг баталсан.<br><br>Компанийн дүрмээр Зам, тээврийн хөгжлийн яам нийт хувьцааны 66 хувийг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 34 хувийг эзэмшиж байна.<br><br>Хувьцаа эзэмшигчдийн хоёрдугаар хурал 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдөр хуралдсан бөгөөд уг хурлаар “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн бүтцийг 27 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан.<br><br>Хувьцаа эзэмшигчдийн гуравдугаар хурал 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хуралдсан бөгөөд уг хурлаар “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн 2018 оны зардлын гүйцэтгэл, 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн, дараагийн шийдвэр (ЗГТ-2018/150) гарсан тул хяналтаас хасах саналтай. |
| | 103 | **БНЭУ-ын Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Газрын тос боловсруулах үйлдвэр барих”** | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Бүтээн байгуулалтын үе шат бүрт Төрийн өмчийн бодлого, | “Бүрэн хэрэгжсэн” – | ЗГ-ын 2018 оны 323 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **төслийн явцын тухай**<br>2018-05-02, № 20<br>XX.9.1. БНЭУ-ын Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай)-ыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулан, явц, үр дүнгийн талаар танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнноров нарт тус тус даалгав. | зохицуулалтын газраас болон Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг байгууллагын төлөөллөөс бүрдсэн Ажлын хэсэг байнгын хяналт тавин ажиллаж байна.<br>Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Засгийн газрын бүрэлдэхүүн болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл 2018 оны 10 дугаар сард дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилтай газар дээр нь очиж танилцсан болно. | 100% | дугаар тогтоо-лоор Төрийн өмчийн хувьцаа эзэмшиг-чийн эрхийг хэрэгжүү-лэгчийг өөрчлөн УУХҮЯ-ыг тогтоосон.<br>Иймд хяналтаас хасах саналтай. |
| | 104 | **БНЭУ-ын Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцын тухай**<br>2018-05-02, № 20<br>XX.9.3. Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д олгох зээлийн санхүүжилтийг ирээдүйд бий болох хөрөнгөөр барьцаалах замаар олгох асуудлыг судлан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Б.Батбаяр нарт даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Засгийн газрын 2018 оны 02 дугаар тогтоолоор “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлэх талаар хэлэлцээ хийхийг ТӨБЗГ-т зөвшөөрсний дагуу холбогдох тооцоо судалгааны үндсэн дээр 250.0 тэрбум хүртэлх төгрөгийн зээлийн гэрээ хийх зөвшөөрлийг ТӨБЗГ-ын 2018 оны 09 дүгээр тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-д олгов.<br>Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид олгох зээл, зээлийн хүүг газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орж, үйл ажиллагаа эхэлсэн үеэс тооцож төлөх талаар Монгол Улсын Хөгжлийн банктай “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК хэлэлцээ хийж, 2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ЗГ-МГТ-3 2018-43 дугаар бүхий 4 талт гэрээ байгуулсан. Тус гэрээг талууд хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 323 дугаар тогтоолоор | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | ЗГ-ын 2018 оны 323 дугаар тогтоо-лоор Төрийн өмчийн хувьцаа эзэмшиг-чийн эрхийг хэрэгжүүл эгчийг өөрчлөн УУХҮЯ-ыг тогтоосон.<br>Иймд хяналтаас хасах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг тогтоосон. | | саналтай. |
| 64 | 105 | **Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2018 оны 1 дүгээр улирлын тайлангийн тухай**<br>2018-05-30, № 23<br>XXIX.1. Тайлантай холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов” гэжээ. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>2018 онд нийт 240 өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авснаас шийдвэрлэгдсэн 224, хяналтад 5, хугацаа хэтэрсэн, шийдвэрлэгдээгүй 11 (ЗХЗХ-1, БТУХ-9, ТӨБХХ-1) өргөдөл, гомдол байна. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд 2017 оны жилийн эцэс, 2018 оны I, II, III улирлын шийдвэрлэлтийн тайланг газрын http://www.pcsp.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн ТӨБЗГ-ын 2018 оны өргөдөл, гомдлын мэдээллийг III улирлын байдлаар гарган ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан нийт 20 иргэн хандаж санал, хүсэлт, гомдол, ирүүлснийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгч ажиллав. Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-д 2018 онд ирүүлсэн өргөдөл гомдлын агуулга: орон нутагт зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагаатай холбоотой 9, худалдан авах ажиллагааны системтэй холбоотой 3, худалдан авах ажиллагааны талаар сургалт явуулах 1, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой 1, газрын албан хаагчтай холбоотой 2, газар эзэмших эрхтэй холбоотой 1, өмчтэй холбоотой 2, лавлагаатай холбоотой 1 өргөдөл, гомдол байна.<br>Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-д иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлийн мөрөөр дутагдал гаргасан 1 албан хаагчийн асуудлыг ТӨБЗГ-ын “Ёс зүйн хороо”-оор хэлэлцэн, сануулга өгч, нийт албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Утга агуулга ижил дараагийн шийдвэр гарсантай холбог-дуулан хяналтаас хасах саналтай. |
| 65 | 106 | **Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор баталсан Төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад ХШҮ хийсэн тайлангийн тухай**<br>2018-06-13, № 26<br>XIX.3.1. Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт туссан асуудлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>ТӨБЗГ-аас хэрэгжилтийг хариуцан зохион байгуулдаг бодлогын баримт бичиг одоогоор байхгүй байна. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт тусгагдсан холбогдох заалтуудын хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөөг батлан холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь ирүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт үүрэг болгов. | үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаа, хуваарийн дагуу хариуцсан байгууллагад хагас, бүтэн жилд тайлагнан мэдээлж ажиллав. | | |
| 66 | 107 | **Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс "Иргэд, олон нийттэй харилцах төв"-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2018 оны эхний хагас жилийн тайлангийн тухай**<br>2018-08-29, № 36<br>XIY.1. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон албан тушаалтанд хандаж иргэдээс 2018 оны эхний хагас жилд "Иргэд, олон нийттэй харилцах төв"-д ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>2018 онд нийт 240 өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авснаас шийдвэрлэгдсэн 224, хяналтад 5, хугацаа хэтэрсэн, шийдвэрлэгдээгүй 11 (ЗХЗХ-1, БТУХ-9, ТӨБХХ-1) өргөдөл, гомдол байна. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд 2017 оны жилийн эцэс, 2018 оны I, II, III улирлын шийдвэрлэлтийн тайланг газрын http://www.pcsp.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн ТӨБЗГ-ын 2018 оны өргөдөл, гомдлын мэдээллийг III улирлын байдлаар гарган ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан нийт 20 иргэн хандаж санал, хүсэлт, гомдол, ирүүлснийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгч ажиллав. Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-д 2018 онд ирүүлсэн өргөдөл гомдлын агуулга: орон нутагт зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагаатай холбоотой 9, худалдан авах ажиллагааны системтэй холбоотой 3, худалдан авах ажиллагааны талаар сургалт явуулах 1, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой 1, газрын албан хаагчтай холбоотой 2, газар эзэмших эрхтэй холбоотой 1, өмчтэй холбоотой 2, лавлагаатай холбоотой 1 өргөдөл, гомдол байна.<br>Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-д иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлийн мөрөөр дутагдал гаргасан 1 албан хаагчийн асуудлыг ТӨБЗГ-ын "Ёс зүйн хороо"-оор хэлэлцэн, сануулга өгч, нийт албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| | | **Тэмдэглэл: 16 шийдвэрийн 24 заалт** | **100% - 21 заалт; 70% - 1 заалт; 30% - 1 заалт; ХБ – 1 заалт; Хэрэгжилтийн хувь – 95.7%** | | |
| | | **Долоо. Засгийн газрын албан даалгавар** | | | |
| 67 | 108 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01 | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдад шударга ёс, хууль дээдлэх зарчмыг баримтлан ажиллах талаар соён | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад: 1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах; | гэгээрүүлэх, сургалтын ажлыг зохион байгуулан ажилласан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны сургалтын төлөвлөгөөний хүрээнд 35, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилт хангах, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор 5, ТӨБЗГ-ын албан хаагчдыг соён гэгээрүүлэх, шинэ мэдлэг, мэдээлэл олгох сургалтын хүрээнд 4, ТӨБЗГ-ын албан хаагчдад “Хууль тогтоомж, сурталчлах сарын аян”-ны хүрээнд 11, нийт 55 (хууль тогтоомжийн сургалт 20, АТГ-ын төлөвлөгөөт сургалт 23, мэргэшүүлэх сургалт 3, соён гэгээрүүлэх 9) удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 1608 албан хаагчийг хамруулсан.<br><br>ТӨБЗГ нь албан хаагчидтай үр дүнгийн гэрээ байгуулахдаа шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан ажиллаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, мэргэжил, мэдлэгээ байнга дээшлүүлэх талаар заалт тусган хэрэгжүүлж байна.<br><br>2018 онд ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ ажил төлөвлөсөн хугацаанд биелүүлээгүй, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй 2 албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулж, 1 албан хаагчийн асуудлыг ТӨБЗГ-ын “Ёс зүйн хороо”-оор хэлэлцэн, сануулга өгч, бусад албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн. | | |
| | 109 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2017-10-26, № 01<br><br>1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг албан хаагчдад сурталчлан таниулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 2018 онд хийгдэх ажлыг байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт 33 заалттайгаар боловсруулж, газрын даргын 2018 оны А/85 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлэв.<br><br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих чиглэлээр Авлигатай тэмцэх газраас 3 гишүүн бүхий олон нийтийн дэд зөвлөлийг гурвалсан гэрээний дагуу ТӨБЗГ-т ажиллуулж байна.<br><br>Тайлант хугацаанд давхар ажил эрхлэлтийн судалгаа гаргаж дүн, дүгнэлт, зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулан, хуулийн заалтыг сурталчлан таниулах арга хэмжээ авсан. Албан хаагчдын ёс | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зүй, шударга байдалд эерэг нөлөө үзүүлэх үүднээс төрийн дуулал, төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагийг сурталчлах арга хэмжээ авч, тусгайлсан газарт байрлуулав.<br><br>Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд хуульд заасан мэдэгдэл, тайлбарыг гарган шийдвэрлүүлж ажиллах талаар ТӨБЗГ-ын албан хаагчид болон харьяа төрийн өмчит хуулийн этгээдийг зөвлөмж чиглэлээр ханган ажиллав. Энэ чиглэлээр тусгайлан зөвлөмж боловсруулж, харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 2018 оны А-1/2869 тоот зөвлөмжийг хүргүүлэв.<br><br>Авлигын хэрэгт холбогдсон, авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ зөрчсөн нь хуулийн байгууллагаар тогтоогдсон дүгнэлтийн дагуу харьяа төрийн өмчит 2 хуулийн этгээдийн удирдлагыг өөрчлөн томилох, 3 хуулийн этгээдийн удирдлагад сахилгын шийтгэл ногдуулах талаар тухайн компанийн ТУЗ-д чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулсан. | | |
| | 110 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2017-10-26, № 01<br><br>1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>2018 оны онд Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан ТӨБЗГ-т нийт 20 иргэнээс санал, хүсэлт, гомдол, ирүүлснийг хүлээн авч, бүртгэлд хамруулан шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллав. Эдгээрийг агуулгаар авч үзвэл, орон нутагт зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагаатай холбоотой 9, худалдан авах ажиллагааны системтэй холбоотой 3, худалдан авах ажиллагааны талаар сургалт явуулах 1, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой 1, газрын албан хаагчтай холбоотой 2, газар эзэмших эрхтэй холбоо байв.<br><br>Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх хүрээнд удирдлагын заалтын дагуу холбогдох албан хаагчдад шилжүүлэн, шийдвэрлэлтэд нь бүртгэлээр хяналт тавин ажиллав. Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан ирүүлсэн санал, хүсэлт гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгсөн байна. Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай үзүүлсэн эсэхийг албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж, дүгнэхэд харгалзан дүгнэж байна. Дутагдал гаргасан 1 албан хаагчийн асуудлыг ТӨБЗГ-ын “Ёс зүйн хороо”-оор хэлэлцэн, сануулга өгч, бусад албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн.<br><br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж байна. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдээс тус байгууллагад ирүүлсэн | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг улирал бүр тогтмол мэдээлж хэвшив. | | |
| | 111 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг дотоод сүлжээ, цаг бүртгэлийн төхөөрөмж, хяналтын камерын системээр бүртгэдэг бөгөөд хяналтыг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах, зөрчил доголдлыг арилгахад чиглэсэн ажлыг албан хаагчдын цалинтай уялдуулах замаар зохион байгуулж байна. Сар бүр хэлтэс, албаны дарга нар цаг бүртгэлийн тайланг хянан баталгаажуулж хэвшсэн. Гадуур ажилтай албан хаагчдын мэдээллийг өмнөх өдөр нь гаргаж Төрийн тусгай хамгаалалтын газрын Харуул хамгаалалтын албаны ажилтанд өгч, байгууллагад нэвтрэх зохион байгуулалтыг хэвшүүлж байна.<br>ТӨБЗГ нь албан хаагчийн мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, чадавхийг бэхжүүлэх замаар тэдний гүйцэтгэл, үр дүнг сайжруулж, ажлын хариуцлагыг дээшлүүлэхэд анхааран ажиллав. “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд газрын 2018 оны сургалтын төлөвлөгөөг газрын даргын 2018 оны А/38 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлсэн. 2018 онд ТӨБЗГ-ын албан хаагчдад зориулж, нийт 55 удаагийн сургалт зохион байгуулан давхардсан тоогоор 1608 албан хаагчдыг хамруулав.<br>ТӨБЗГ-т интернетийн зохистой хэрэглээг хангах, албан хаагчдын ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авч, 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн Төрийн холбооны газартай хамтран интернетийн олон нийтийн сүлжээ (facebook, twitter)-д албаны компьютерээс хандах боломжгүй болгох тохиргоог хийж, интернетийн хэрэглээг хязгаарлав.<br>Засгийн газрын 2018 оны “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагад интернетийн зохистой хэрэглээг бий болгох арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоол, 16 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, харьяа төрийн өмчит хуулийн этгээдэд уг тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А-1/2160 дугаар албан бичгээр зөвлөмж хүргүүлж, ажлын цагаар нийгмийн цахим сүлжээг ашиглахгүй байх хязгаарлалт хийв.<br>Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Төрийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн 3 албан хаагчийн асуудлыг байгууллагын Ёс зүйн хорооны | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хурлаар хэлэлцүүлж, Төрийн албаны тухай хуулийн дагуу 2 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан, 1 албан хаагчид сануулга өгч, нийт албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн. Эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан 6 албан хаагчтай холбоотой асуудлаар сонсох ажиллагаа хийж, цаашид алдаа дутагдал гаргахгүй байх талаар анхааруулав. | | |
| | 112 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Албан хаагчдыг тогтвортой суурьшилтай ажиллуулах, төрийн албаны залгамж чанарыг хангаж, идэвх санаачилгыг өрнүүлэн ажиллах бодлогын үүднээс албан хаагчдын үр дүнг үнэлж дүгнэсний үндсэн дээр урамшуулах, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авав. Энэ хүрээнд ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгох журам"-ын хэрэгжилтийг хангаж, 10 албан хаагчид 116.0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг, 8 албан хаагчид 1.3 сая төгрөгийн тусламж, 3 албан хаагчид 0.9 сая төгрөгийн тэтгэмж, давхардсан тоогоор 143 албан хаагчид нийт 59.6 сая төгрөгийн урамшууллыг олгосон. Мөн 64 албан хаагчид газрын үйл ажиллагааны нэмэлт орлогоос 120.8 сая төгрөгийн урамшуулал олгосон болно. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Шинэ жилийн баярыг тохиолдуулан ТӨБЗГ-т үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 1 албан хаагчийг "Алтан гадас" одонгоор, 6 албан хаагчийг ТӨБЗГ-ын "Жуух бичиг"-ээр, 4 албан хаагчийг салбарын "Тэргүүний ажилтан" тэмдгээр, 2 албан хаагчийг салбарын "Хүндэт жуух" бичгээр, 7 албан хаагчийг Залуучуудын холбооны шагнал, 5 албан хаагчийг ТӨБЗГ-ын "Тусгай мөнгөн шагнал"-аар тус тус шагнаж, урамшуулав.<br>ТӨБЗГ-ын сул орон тоонд хууль тогтоомжид заасан шаардлага хангасан 5 албан хаагчийг төрийн жинхэнэ албанд томилон, тангараг өргүүлж, 8 албан хаагчийн чиг үүргийг өөрчилж, хэлтэс хооронд шилжүүлэв. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| | 113 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>2018 онд ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ ажил төлөвлөсөн хугацаанд биелүүлээгүй, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй, ажил цалгардуулсан 2 албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу сануулах сахилгын шийтгэл ногдуулж, 1 албан хаагчийн асуудлыг ТӨБЗГ-ын "Ёс зүйн хороо"-оор | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх; | хэлэлцэн, сануулга өгч, бусад албан хаагчдад зөвлөмж хүргүүлсэн<br><br>Дараах албан даалгаврыг харьяа төрийн өмчит 72 хуулийн этгээдэд хүргүүлэв:<br>1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, хариуцлага, сахилгыг дээшлүүлэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/350 дугаар албан бичгээр;<br>2. Байгууллагын соёлыг төлөвшүүлэх, төрийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, компанийн гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтны ёс зүй, харилцааны талаар иргэдээс ирүүлж буй гомдол, санал, зөрчлийг арилгах, удирдлага, хяналтын тогтолцоог оновчтой зохион байгуулж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар ТӨБЗГ-ын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А-2/3196 дугаар албан бичгээр;<br>3. Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах талаар ТӨБЗГ-ын 2018 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А-2/3440 дүгээр албан бичгээр.<br><br>Эрхэлсэн ажилдаа алдаа дутагдал гаргаж, түүний улмаас улсын хэмжээний салбарын үйл ажиллагаа доголдох нөхцөл байдал үүсгэсэн, контрактаар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэмт хэрэгт холбогдсон, авлигын эсрэг хууль тогтоомжийг зөрчсөн нь холбогдох хуулийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон зэрэг үндэслэл, шалтгаанаар төрийн өмчит 10 компанийн гүйцэтгэх удирдлагад хариуцлага тооцуулах талаар тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж, чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулав. Энэ хүрээнд 7 компанийн гүйцэтгэх захирлыг чөлөөлж, шинээр томилсон, 3 компанийн гүйцэтгэх захиралд 3 сар хүртэлх хугацаагаар цалингийн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээг бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байна. | | |
| | 114 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>1. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>ТӨБЗГ-т шинээр гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажил төлөвлөгдөөгүй.<br>ТӨБЗГ-ын 2017 оны 90 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”, Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлагыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллав.<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үр ашгийг сайжруулах чиглэлээр Засгийн газрын 2018 оны 08 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, хариуцлага, сахилгыг дээшлүүлэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/350 дугаар албан бичгээр албан даалгавар хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна.<br>Засгийн газрын 2018 оны 09 дүгээр тогтоолоор алдагдалтай ажиллаж байсан болон үйл ажиллагаа нь зогссон “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК, “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК, “Монгол тамга” ТӨҮГ, “Монгол тариалан” ТӨҮГ, “Монгол мах” ТӨҮГ-ыг татан буулгасан.<br>Контрактаар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн төрийн өмчит 5 хуулийн этгээдийн захиралтай хариуцлага тооцон контрактыг 6 сараар сунгаж, хагас жилийн ажлын үр дүнг харгалзан дахин 6 сараар сунгасан. Түүнчлэн, салбарын сайдын санал, хангалтгүй ажилласан шалтгаан үндэслэлээр 4 хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлыг өөрчлөн томилсон. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | | **Албан даалгавар:**<br>**1 шийдвэрийн 7 заалт.** | **100% - 7 заалт; Хэрэгжилтийн хувь - 100.0%.** | | |

**(Нийт 7 төрлийн 67 шийдвэрийн 114 заалтын хэрэгжилтийг тайлагнав)**

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (нэр төрлөөр)
(2018 оны жилийн эцсийн дүн)

| Д/д | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл | Шийд-вэрийн тоо | Хэрэг-жилтийг тооцсон заалтын тоо | Үүнээс: | | | | | Хэрэгжилтийн явц (хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бүрэн хэрэгжсэн (100 %) | Хэрэгжих шатанд (70 %) | Хэрэгжилт хангалтгүй (30 %) | Хэрэгжээгүй (0 %) | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ.) | |
| 1 | УИХ-ын тогтоол | 3 | **4** | 3 | | | | 1 | **100.0** |
| 2 | Ерөнхийлөгчийн зарлиг | 2 | **2** | 2 | | | | | **100.0** |
| 3 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж | 1 | **1** | 1 | | | | | **100.0** |
| 4 | Засгийн газрын тогтоол | 42 | **74** | 55 | 13 | | | 6 | **94.3** |
| 5 | Ерөнхий сайдын захирамж | 2 | **2** | | 1 | | | 1 | **70.0** |
| 6 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 16 | **24** | 21 | 1 | 1 | | 1 | **95.7** |
| 7 | Засгийн газрын албан даалгавар | 1 | **7** | 7 | | | | | **100.0** |
| **Хэрэгжилтийн дүн (шийдвэр, заалтын тоо)** | | **67** | **114** | **89** | 15 | **1** | | **9** | **95.1 (дундаж хувь)** |

ТАНИЛЦСАН:
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНБАТ

ХЯНАСАН:
ДЭД ДАРГА А.ДАГВАДОРЖ

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ